



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Дархан-Уул аймаг
2023 он

Байршил

Монгол улс,
Дархан-Уул аймаг
Дархан сум,
Үйлдвэрийн дүүрэг

Холбоо барих

Утас: (976) 70373021
Факс: (976) 70373021
И-мэйл: darhanpp@mongol.net
Вэбсайт: <http://www.dpp.mn>

АГУУЛГА

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС	1
“ДДЦС” ТӨХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ	3
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ	4
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	5
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	6
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА	8
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	9
ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ЗАСВАР	10
ЧАНАР, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	15
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ	17
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	18
МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	22
ДОТООД АУДИТ	23
ХҮНИЙ НӨӨЦ	24
ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, ЦАЛИН ХӨЛС	26
КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	27
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	30

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС

АЛСЫН ХАРАА

2030 он гэхэд хүчин чадлаа бүрэн ашигласан, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хүний хөгжлийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай компани байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Хөгжилд хөтөлсөн найдвартай үйлдвэрлэгч компани байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, бүтээлч ажилтан
- Эерэг хандлага
- Эрүүл, аюулгүй орчин
- Багийн ажиллагаа
- Түүхэн замнал

ЧАНАРЫН БОДЛОГО

Бид цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийг үр ашигтай горимоор, өндөр чанартай, хатуу хяналттай, нарийн хэмжилттэй, сахилга бат хариуцлагатай шуурхай явуулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хангана.

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Дарханы дулааны цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компани нь Дархан-Уул аймгийн үйлдвэрийн дүүрэгт нийтдээ 47.7 га талбайд оршино. Тус станцын суурийг 1963 онд тавьж Сайд нарын Зөвлөлийн 1964 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 222 дугаар тогтоолоор байгуулсан түүхтэй. 1965 оны 10-р сарын 02-нд анхны үндсэн тоноглолуудыг ашиглалтад оруулсан ба эрчим хүчний салбарын ууган үйлдвэрүүдийн нэг юм.

Тус станц нь Дархан Сэлэнгийн бүс нутгийг цахилгаанаар, Дархан хотыг дулааны эрчим хүчээр хангадаг ба манай улсын төвийн эрчим хүчний системийг бүрдүүлэгч нэг үндсэн эх үүсвэр болдог. Жилдээ 302 сая кВт/ц цахилгаан эрчим хүч, 1196 мянган Гкалл дулааны эрчим хүч боловсруулах хүчин чадалтай байгуулагдсан ба 35 МВт-ын турбингенераторыг суурилуулснаар суурилагдсан хүчин чадал 83 МВт болсон. Жилд дунджаар 400 гаруй мянган тонн нүүрсийг Шарын гол болон Багануурын уурхайгаас худалдан авч технологийн хэрэгцээндээ ашигладаг.

БКЗ-75-39ФБ маркын 75 тн/цаг уур боловсруулах хүчин чадалтай 9 зуух,

АПТ-12-35-10 маркийн тус бүр нь 12 МВт чадалтай 4, АПТ-35/39-3.4-1.0 маркын 35МВт чадалтай 1 турбин генератортай.

Үндсэн ба туслах тоноглолууд нь сүүлийн үеийн хянах хэмжүүр автоматикийн хэрэгслэлээр тоноглогдсон. Үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчээ 40МВа хүчин чадалтай хоёр трансформатораар дамжуулан хэрэглэгчдэд түгээдэг бөгөөд 110 кВ-ын 113, 114-р шугамаар Монгол улсын төвийн эрчим хүчний системтэй холбогддог. Мөн хэрэглэгчдийг Сүхбаатар, Дархан, Ерөөгийн 110кВ-ын, РП-11-ийн А, Б шугамаар 35кВ-ын, Дархан хотын үйлдвэрийн районы зарим хэрэглэгчдийг 5Ш1, 7Ш1-ийн 6кВ-ын шугамаар тус тус тэжээдэг.

Тус станц нь Дархан хотыг бүхэлд нь хэрэгцээний халуун ус, дулаацуулгаар бүрэн хангаж байгаагийн зэрэгцээ үйлдвэрүүдэд шаардлагатай технологийн хэрэгцээний уур нийлүүлдэг. Жилд дунджаар 3 сая тонн орчим боловсруулсан халуун усыг сүлжээнд нээлттэй системээр нийлүүлдэг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Монголын эрчим хүчний гол эх үүсвэрүүдийн нэг, Дархан хотын гал голомт болсон Дарханы дулааны цахилгаан станц Төрийн өмчит хувьцаат компанийнхаа нийт хамт олон, энэ компанийн үе үеийн ахмадууд, бүх хамтран ажилласан байгууллага, иргэд та бүхэнд тус компанийн 2022 оны ажлыг тайлагнан мэндчилж байна.

Тус компанийн хамт олон 2022 онд системийн хэмжээнд шаардлагатай цахилгаан эрчим хүч нийлүүлэх үйл ажиллагаанд хариуцлагатай, үр нөлөөтэй оролцсон ба цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх төлөвлөгөөт зорилтоо бүрэн биелүүлж, тодорхой зардлуудыг бууруулан ажиллалаа. Үйлдвэрлэлийн төлөвлөгөө давж биелснээр борлуулалтын орлого өнгөрсөн оноос 3.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, үндсэн үйлдвэрлэлийн зардлыг төлөвлөснөөс 142.5 сая төгрөгөөр бууруулсан.

Компанийн хамт олон төлөвлөсөн их, урсгал засварын ажлыг чанартай бүрэн гүйцэтгэснээр 2022-2023 оны өвлийн их ачааллыг зөрчил доголдолгүй амжилттай давж байна. Үүний зэрэгцээ ахмадууд, ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг салбарын хамт /тариф/-ын хэлэлцээр, хамтын гэрээний хүрээнд амжилттай шийдвэрлэж ажилласан.

Монгол улсын хөгжил, цэцэглэлтэд өөрийн хувь нэмрээ оруулан хөдөлмөрлөж байгаа Дарханы дулааны цахилгаан станцын хамт олон та бүхэнд болон хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч байгууллага, хувь хүмүүс, хэрэглэгчдэдээ эрүүл энх, ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.БИЛГҮҮН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Дарханы дулааны цахилгаан станцын нийт ажилтнууд, ахмадууд, компанийн Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, харилцагч байгууллага, иргэд та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсэн мэндчилье.

Манай компани цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэн ард иргэд, үйлдвэр аж ахуйн байгууллагуудыг тав тухтай амьдарч ажиллах нөхцөлөөр найдвартай ханган 58 дахь жилдээ тогтвортой үйл ажиллагаа явуулж улс орныхоо

хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Бид 2022 онд 346.8 сая кВт цахилгаан эрчим хүч түгээж, төлөвлөгөөг 5.2 сая кВт-аар илүү буюу 101.5 хувиар, 601.3 мянган Гкал дулааны эрчим түгээж, төлөвлөгөөг 11.3 мянган Гкал-аар илүү буюу 101.9 хувиар биелүүлж борлуулалтын орлогын төлөвлөгөөг зорилтот түвшинтэй харьцуулахад 101.7 хувиар давуулан биелүүлэв.

Техник эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн хувьд тоноглолын оновчтой хэмнэлттэй горимыг барьж, нэгж хүчин чадал ашиглалтыг сайжруулан найдвартай ажиллагааг хангаж ажилласнаар ДХЦЭХ-ийг 0.52 %-аар хэмнэж борлуулалтын орлогыг нэмэгдүүлсэн.

Компанийн хэмжээнд нийт 615 тоноглолд их, урсгал засварын ажлыг хийсэн ба үүнээс Зуух №3, Турбин №3-ын их засварын ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэсэн нь өвлийн их ачааллыг амжилттай давахад чухал ач холбогдолтой байв. Хөрөнгө оруулалтаар 21 нэр төрлийн бараа материалыг 1,086.9 сая төгрөгөөр худалдан авч суурилуулан ашиглалтад хүлээн авсан. Техник зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд дүүрсэн үнсэн санг сэргээн ашиглалтад оруулах, турбингенератор №5-ын генераторт газардлагын бие даасан хамгаалалт суурилуулах, турбингенератор №2-ын өдөөгч шинэчлэх, нарны цахилгаан үүсгүүр суурилуулах, турбины туслах тоноглолыг компьютерын хяналт удирдлагад шилжүүлэх, конторын дулааны хэрэглээг хаалттай системд шилжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

Бидний 2022 оны ажлыг үнэлж Дархан-Уул аймгийн 2022 оны “ТОП-5 аж ахуйн нэгж”, “Оны шилдэг татвар төлөгч”-өөр шалгаруулсан.

Улиран одож буй 2022 онд бидэнтэй хамтран ажилласан бүх байгууллага, иргэдэд талархсанаа илэрхийлж ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

“ДДЦС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ЖАРГАЛСАЙХАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн хувьд Компанийн засаглал нь Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон хэрэглэгч, харилцагчид, ажилтнуудын хоорондын төрөл бүрийн харилцааг сайжруулах, оролцоог хангах, компанийн хөгжлийн зорилтуудыг зөв арга барил, зохистой зарчмуудаар чанартай, бүтээмжтэй хэрэгжүүлэх, хяналт, мэдээллийн цогц тогтолцоог бий болгох бүтэц зохион байгуулалт бүхий үйл явц юм.

Манай компани Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, компанийн засаглалын кодекс, компанийн засаглалын холбогдох журмуудыг мөрдлөг болгон Монголын болон гадаад улс орнуудын засаглалын шилдэг туршлагаас суралцаж салбартаа тэргүүлэгч байх, эрх мэдлийн зөв хуваарилалтад тулгуурласан хариуцлага хүлээх чадвар бүхий ил тод байдлыг дэмжсэн засаглалын тогтолцоог бий болгох зорилт тавин ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “ДДЦС” ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг “Сайн”, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 06 дугаар тогтоолын 1-р хавсралтаар Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг, мөн өдрийн 07 дугаар тогтоолын 1,3 дугаар хавсралтаар “ДДЦС” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг тус тус томилон ажиллуулсан.

“ДДЦС” ТӨХК нь 100 хувь төрийн өмчит компани бөгөөд эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Засгийн газрын 2018 оны 335 дугаар тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлж байна. Эрчим хүчний яамнаас компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлуудад удирдамж өгч ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг тухайн жилийн компанийн үйл ажиллагаа, зорилтот түвшний биелэлттэй уялдуулан дүгнэж Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг жил бүр хувьцаа эзэмшигчдий хурлаар сонгодог. 2022 онд “ДДЦС” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч 6 гишүүн, хараат бус 3 гишүүн, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

Төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн салбарт ажил мэргэжлийн хувьд мэргэшсэн, өндөр туршлага чадвартай гишүүдээс бүрддэг. “ДДЦС” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүд компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын сургалтанд хамрагдсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, засаглалын тогтолцоог сайжруулах үүднээс жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажилладаг.



П.БИЛГҮҮН

ТУЗ-ийн дарга

Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын дарга



П.ДАВААДОРЖ

ТУЗ-ийн гишүүн

Эрчим хүчний яамны Хяналт дотоод шинжилгээ, үнэлгээ, аудитын газрын ахлах шинжээч



Б.АРИУНДЭЛГЭР

ТУЗ-ийн гишүүн

Эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч



Д.ОДМАА

ТУЗ-ийн гишүүн

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн



Д.ТӨРТУЛГА

ТУЗ-ийн гишүүн

Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийн газрын дулааны хэлтсийн шинжээч



Б.ШҮР-ЭРДЭНЭ

ТУЗ-ийн гишүүн

Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын зохион байгуулагч



Ж.БАТТУЛГА

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ХААИС-ийн Эдийн засгийн бизнесийн сургуулийн багш, менежментийн ухааны доктор (Ph.D)



Л.АЛТАНЗУЛ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эрчим хүчний аудитор

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн удирдах зөвлөл нь хэлэлцэж шийдвэрлэх болон хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг жилээр төлөвлөн, сар бүр ээлжит хурал зохион байгуулж 2022 онд Эрчим хүчний яамнаас 13 удаа хэлэлцэх асуудлаар удирдамж авч хуралдан 28 тогтоол, 11 хурлын тэмдэглэлээр шийдвэр гаргаж үүрэг даалгавар өгсөн. Тогтоол шийдвэрийн биелэлт 100%-тай байна. Компанийн тухай хуулийн дагуу аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороог тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба уг хороод нь хуульд заасан эрх, үүргийн дагуу холбогдох асуудлуудыг хэлэлцэн зохих шийдвэр гарган ажилласан. Үүнд:

- Компанийн 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт-1 удаа, Компанийн 2022 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тодотгол оруулах асуудлаар 2 удаа, Компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг дэмжих тухай асуудлаар 1 удаа, ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулах асуудлаар 2 удаа, Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2022 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийн талаар 1 удаа.
- Санхүүгийн тайлан тэнцэлд өгсөн Аудитын дүгнэлтийн тухай 1 удаа, санхүүгийн өр авлагын тухай 2 удаа, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийн биелэлтийн тухай 1 удаа.
- Компанийн техник зохион байгуулалт үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд 2021-2022 оны өвлийн их ачааллыг давсан ажлын тайлангаар 1 удаа, ээлжит бүрэн зогсолтын ажлын эзлэхүүн, ажлын гүйцэтгэл, өвлийн бэлтгэл ажлын явц, тоноглолын их засвар, ТЗБАХ, ХО-аар хийгдэж байгаа ажлын талаар 2 удаа, 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаар 1 удаа, үндсэн хөрөнгө актах тухай асуудлаар 1 удаа, үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх 1 удаа, Хувьцаа эзэмшигч болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар 2 удаа, бусад цаг үеийн шаардлагаар 17 асуудлаар тухай бүр хэлэлцэж шийдвэр гаргасан.
- 2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн ирц 100% байна.

Нэр дэвшүүлэх хороо нь:

Гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хянаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн гэрээ байгуулах шийдвэр гаргуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг бүртгэн Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч сонгон шалгаруулалт хийж Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлсэн.

Цалин урамшууллын хороо нь:

2023 оны эдийн засгийн үзүүлэлт зорилт түвшинд Ажилтнуудын цалингийн санг нэмэгдүүлж нийт 10 хувиар үндсэн цалинг нэмэхээр дүгнэлт гарган батлуулсан. Компанийн ажилтнуудад олгох 2022 оны жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсний хэмжээ тогтоосон тооцооллыг хянаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар оруулсан. Гүйцэтгэх захирлын цалин хөлсний тооцооллыг хийж санал боловсруулан шийдвэр гаргуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн хэмжээг тогтоож, 2021 оны зардлын гүйцэтгэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, 2022 оны зардлыг төлөвлөн батлуулсан.

Аудитын хороо нь:

Компанийн 2021 оны санхүүгийн жилийн тайлан баланст Аудитын хорооны дүгнэлтийн гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж дүгнүүлсэн. 2022 оны Худалдан авалтын төлөвлөгөөний биелэлттэй танилцаж дүгнэлт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан. 2022 оны 1, 2, 3-р улирлын тайлан баланстай танилцаж нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, мэдээллийн үнэн бодит байдалд хяналт хийж, Хяналтын хэлтсийн үйл ажиллагаатай танилцан зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан.

Гүйцэтгэх захирал нь компанийн бодлого, хэтийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, жил бүрийн зорилтот түвшнийг биелүүлэхэд чиглэсэн, үйлдвэрлэлийн болон бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааг өөрийн эрх үүргийн хүрээнд удирдан зохион байгуулан ажиллаж байна.

Компанийн гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй 8 бүлэг 100 заалт бүхий онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан. Биелэлт 100% байна. Гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж жилийн эцсийн байдлаар Төлөөлөн удирдах зөвлөл үнэлэлт дүгнэлт өгч дүгнэдэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврыг 100%-аар ханган ажилласан.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаатай холбоотой их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй байна.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



М.ЖАРГАЛСАЙХАН
Гүйцэтгэх захирал



Б.ХАШ-ЭРДЭНЭ
Ерөнхий инженер



Х.АЛТАНГЭРЭЛ
Инженерийн албаны дарг.



Ц.ЭНХБААТАР
Захиргаа удирдлагын
хэлтсийн дарга



Ц.УУГАНБАЯР
Санхүү бүртгэлийн
хэлтсийн дарга



Л.БАЛТ
Хяналтын хэлтсийн дарга



Э.АЛТАНТУЛГА
Хангамж үйлчилгээний
хэлтсийн дарга



Д.СЭРГЭЛЭН
ТУЗ-ийн нарийн бичгийн
дарга

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДДЦС" ТӨХК 2022 онд БКЗ-75-39 ФБ маркийн 9 зуух, АРТ-12-35/10 маркийн 4, ПТ-35/39-3.4-1.0 маркийн 1 турбингенератортай цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаа явууллаа.

2022 онд:

✚ 405.6 сая кВт цахилгаан эрчим хүч боловсруулж төлөвлөгөөг 3.66 сая кВт-аар илүү буюу 101.5 %-аар ,

✚ 601.3 мянган Гкал дулааны эрчим түгээж төлөвлөгөөг 16.5 мянган Гкал буюу 101.9% биелүүлсэн.

Техник эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн хувьд:






✚ Тоноглолын нэгж хүчин чадал ашиглалтыг сайжруулж найдвартай ажиллагааг хангаж ажилласнаар ДХЦЭХ-ийг 0.52%-аар хэмнэж борлуулалтын орлогыг нэмэгдүүлсэн.

✚ Зуухны тооцоор галлах технологийг түлхүү ашигласнаар зуухны галлагааны мазут зарцуулалтыг 56,044 тонноор хэмнэсэн.

✚ Гаднаас авах ус сувгийн усны зарцуулалтын хэмнэлттэй техникийн горим оновчлолыг баримтлан хэрэгжүүлснээр 66.7 тонн ус хэмнэсэн.

✚ Засвар, горим үйлчилгээний чанарыг сайжруулснаар турбины вакуумыг 3%-иар, зуухны утааны хийн температурын зөрчлийг 3.5%-аар бууруулан нормт хэмжээг ханган, ДХЦЭХ-ийг 0.52%-аар бууруулан ажилласнаар түлшний хувийн зарцуулалтыг хэмнэсэн.

Жишмэл түлшний хувийн зарцуулалтыг цахилгаанд 6.69 гр/кВт.ц, дулаанд 3.83 кг/Гкал-аар хэмнэж санхүү эдийн засгийн балансын үр ашгийг дээшлүүлсэн.



ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ЗАСВАР

Эрчим хүчний үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангахад үндсэн ба туслах тоноглолын их, урсгал засварын ажлын чанар, өвлийн их ачааллыг давах бэлтгэл ажлын гүйцэтгэл ихээхэн ач холбогдолтой байдаг. 2022-2023 оны өвлийн бэлтгэл хангах 61 заалт бүхий ажлын төлөвлөгөөг гарган 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.

Их, урсгал засварын ажил:

Компанийн хэмжээнд нийт 592 тоноглолд их, урсгал засварын ажлыг 5,343.2 сая төгрөгөөр хийхээр төлөвлөн 615 тоноглолд 3,424.4 сая төгрөг зарцуулан хийж гүйцэтгэв. Үүнд:

Зуух №3, Турбин №3-д их засварын ажлыг төлөвлөн хуваарийн дагуу хийж гүйцэтгэн үндсэн тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллав. Зуух №3-ын их засварын ажилд гүйцэтгэгч шалгараагүй учир өөрсдийн хүн хүчээр өрлөг дулаалга, хаалт арматур, эргэх механизм, үнс баригчийн засварын ажлуудыг гүйцэтгэв.

Хөрөнгө оруулалтаар:

Төлөвлөгөөгөөр нийт 21 нэр төрлийн барааг худалдан авахаар төлөвлөн Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороогоор батлуулж 21 нэр төрлийн бараа материалыг 1,086.9 сая төгрөгөөр худалдан авч суурилуулан ашиглалтад хүлээн авсан. Үүнээс

- ❖ Турбингенератор №5-д газардлагын бие даасан хамгаалалт шинээр суурилуулах ажлыг амжилттай хэрэгжүүлэн ажиллав.

Техник зохион байгуулалтын арга хэмжээ:


Техникийн шинэчлэл, зохион байгуулалтын арга хэмжээнд: 5 ажлыг төлөвлөн 2,446.9 сая төгрөг зарцуулан 100% хэрэгжүүлэв. Үүнд:

- ❖ Дүүрсэн үнсэн санг сэргээн ашиглалтад оруулах 2-р шатны ажил
- ❖ Турбингенератор №2-ын өдөөгч шинэчлэх
- ❖ Нарны цахилгаан үүсгүүр суурилуулах
- ❖ Турбины туслах тоноглолыг компьютерын хяналт удирдлагад шилжүүлэх
- ❖ Конторын дулааны хэрэглээг хаалттай системд шилжүүлэх
- ❖ Бульдозер №1-ийн мотор шинээр солих



2022 ОНД ХИЙГДСЭН ТОМООХОН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ЗАСВАРЫН АЖЛУУД:

1. Сэргээн засварласан үнсэн сан.



Үр дүн:

Одоо ашиглаж байгаа үнсэн сан №5 нь 95% дүүрэлттэй, шинэ үнсэн сан байгуулах ажлыг хийхэд өртөг зардал өндөртэй учир өөрийн хөрөнгөөр 2021, 2022 онуудад, 2 үе шаттай хэрэгжүүлэв. 2022 онд хоёр дах үе шатыг 6-р сарын 15-аас, 11-р сарын 01 хүртэл гүйцэтгэв. Батлагдсан зураг төслийн дагуу үнсэн сангийн доторлогоо, нягтруулаг, үнс зайлуулах шугам хоолой, тунгаасан далантай холбогдох байгууламжийг угсрах монтажлах ажлыг хийж засварын ажил бүрэн дууссан. Үнсэн санг 2023 онд ашиглахаар төлөвлөн ашиглалтын түвшнийг гаргаж байна.

2. Турбингенератор №2-ын өдөөгчийн шинэчлэл.







Үр дүн:

Турбингенератор №2-ын ВТ-75 төрлийн үндсэн өдөөгч нь 2007 онд гэмтэж ашиглах боломжгүй болсон. ВТ-75 өдөөгчийн үйлдвэрлэл зогссон, сэлбэг олдохгүйн улмаас ЦТЛ-ийн инженерүүд трансформатор, шулуутгагч диод ашиглан өдөөгч хийж 2022 он хүртэл ашигласан. Уг өдөөгч нь автоматаар хүчдэл тохируулах боломжгүй, хамгаалалтын хувьд найдвартай байдлыг бүрэн хангаж чадахгүй учир шинэчлэл хийх ажлыг зохион байгуулав. Өдөөгчийн шинэчлэл хийгдсэнээр генераторын хүчдэл автоматаар тохируулах AVR, APH системтэй болсон. Хуурмаг чадлын горим /VAR/, чадлын коэффициентын горим /cosφ/ нэмэгдсэн, бодит чадал болон хуурмаг чадлын тохируулга хийгдэнэ. Богино залгаа, гүйдэл хүчдэлийн савлалтын үеийн бичлэгийн архивын сан үүсгэх боломжтой болсон. Өдөөлтийн хүчдэл, бодит чадал, хуурмаг чадлын параметруудийг гэдрэг холболтоор хэмжих, PID тооцоолол хийх боломжтой болсон. Энэ нь гаралтын хүчдэлээр тохируулга хийх корректор, гүйдлээр тохируулга хийх компаундирование хязгаар нэмэгдсэн. Мөн потенциометр, нум унтраах эсэргүүцэл, контактор зэрэгт хийгдэх засварын зардалд хэмнэлт гарч байна.

3. Нарны цахилгаан үүсгүүр шинээр суурилуулах.



Үр дүн:

Компанийн оффисын байрны цахилгааны хэрэглээг нарны үүсгүүрээр хангаж дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг хэмнэж үйлдвэрлэлийн түгээлтийг нэмэгдүүлэх боломж бүрдүүлсэн. “Ж-Повер” ХХК-тай хамтран 2022 оны 06-р сараас 2022 оны 09-р сарын 10-ыг хүртэл нийлүүлэлт, угсралт, суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэв. Нийт 100 ширхэг 570 ваттын чадалтай нарны панелиар цагт 50 кВт цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх хүчин чадалтайгаар суурилуулсан. Суурилагдсанаас хойш 2022 он дуустал 15,090 кВт-ын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн өөрийн хэрэгцээнд ашиглан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, агаарт хаях хүлэмжийн хийг 15,985.0 кг-аар бууруулсан байна.

4. Турбины туслах тоноглолыг компьютерийн хяналтад шилжүүлэх.




Үр дүн

Хуучин хэмжүүрүүдийг орчин үеийн нарийвчлалтай 36 ширхэг аналог гаралттай хэмжүүрүүдээр шинэчилснээр хэмжилт нарийвчлалтай, алдаа багатай заах нөхцөл бүрдсэн. Тоноглолын ажиллагааг хянах, хэмжих хэрэгслүүдийн утга, датаг компьютероос хянах, тохируулах, архивлах бүрэн боломжтой. Тоноглолын тохируулга хийх, 5 ширхэг хаалт, клапаны гүйцэтгэх механизмыг орчин үеийн гүйдлийн оролт гаралтын удирдлагатай гүйцэтгэх механизмаар сольж алсын зайнаас, нэг цэгээс удирдах, горим, параметрийг бодит цаг хугацаанд зэрэг хянах боломж бүрдсэн. Туслах тоноглолын хэмжүүрүүдийн 1,300м хуучин кабелийг шинээр татсан учир гарах гэмтэл 90 хувиар буурна.

Туслах тоноглолын машинистуудын ажлын байрны орчин сайжирч эрүүл, аюулгүй ажлын байр бий болж, ажлын ур чадварыг сайжруулах, үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил, гэмтэл буурна.

5. Конторын дулааны хэрэглээг хаалттай системд шилжүүлэх.






Үр дүн:

Халаалтын улиралд гадна агаарын температуртай уялдуулан халаах хэрэгслийг автоматаар тохируулах дулааны эрчим хүчний ухаалаг системтэй орчин үеийн дэвшилтэт технологи бүхий эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг суурилуулсан. Үүний үр дүнд ашиглалт болон засварын зардлыг 60% бууруулах боломж бүрдсэн ба дотоод хэрэгцээний дулааны эрчим хүчний хэрэглээг 20,017 Гкал-аар бууруулан энэ хэмжээгээр компанийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлсэн.

6. Бульдозерын мотор шинээр суурилуулах.




Үр дүн:

Бульдозерын моторыг шинээр тавьснаар нүүрс дамжуулах найдвартай ажиллагаа сайжирч, ашиглалтын хугацаа 12 жилээр уртсах боломжтой болсон.

ЧАНАР, БҮТЭЭМЖ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016

Компанийн хэрэглэгч, сонирхогч талуудын хэрэгцээг хангах, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 2022 онд 4 үндсэн чиглэлээр 10 чанарын зорилтыг дэвшүүлж 89,2% биелүүлсэн. Чанарын менежментийн тогтолцооны хүрээнд 2022 онд хэрэглэгч байгууллагуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн өмнөх оноос 82-89% буюу 7%-аар нэмэгдсэн бөгөөд Стандарт хэмжил зүйн газраас чанарын менежментийн тогтолцооны ээлжит магадлах аудитыг 2022 оны 12-р сарын 27-30-ны хооронд хийж, аудитаар үл тохирол илрээгүй, стандартыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эзэмшүүлэх зөвшөөрлийг олгосон.



Цаашдаа “Компанийн 2030 он хүртэлх стратеги төлөвлөгөө”-ний дагуу ажилтнуудын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх улмаар компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Мэдлэгийн менежмент”-ийг хэрэгжүүлэх, эрчимжүүлэхээр Монголын бүтээмжийн төвтэй хамтран ажиллаж байна.

Анх 2006 оноос хэрэгжиж буй бүтээмж дээшлүүлэх суурь арга хэрэгслийг хэвшүүлэх, идэвхжүүлэх, сайжруулах ажлуудыг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байна. Ажлын байрны соёл 5С-ийн шаардлагыг хангах зорилгоор 2022 онд 258 ажлын байранд 1,532 удаа аудит хийж нийт 311 үл тохирол илрүүлснээс 268 үл тохирлыг залруулж, ажлын байрны дундаж түвшин 4.07 хүрч чанарын зорилтоо биелүүлсэн. Ингэснээр ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалт, аюулгүй байдлыг хангахад чухал нөлөө үзүүлсэн. Кайзен саналын системд 2022 онд 191 ажилтан оролцож 634 шинэ, шинэлэг сайжруулалтын санал, санаачилгыг гаргаснаас 190 санал дэмжигдэж 124 саналыг хэрэгжүүлсэн байна. 2021 оноос шинээр хэрэгжүүлж буй энгийн


сайжруулалтын ажлын системд 2022 онд нийт давхардсан тоогоор 613 ажилтан 705 ажлыг хэрэгжүүлж, ажлын байрны сайжруулалтын ажлыг сар бүр тогтмол хийж хэвшсэн. Чанарын дугуйлангийн төслийн ажлаар 2022 онд өөрсдийн ажилдаа тулгамдаж буй асуудлыг оновчтой шийдвэрлэх 106 төсөл хэрэгжүүлсэн нь бүтээмжийн хөдөлгөөнийг эхлүүлснээс хойших хамгийн өндөр үзүүлэлт болсон.

Төслүүдээс онцлон дурдвал:

- “Тээрмийн салхилуурын ажлын дугуйн хүрз матагч хийх” - Эко чанарын дугуйлан,
- “Бульдозерын кондейшин моторыг сэргээн засварлах” – Эрчим чанарын дугуйлан,
- “Шин матагч хийх төсөл” – Пирамид чанарын дугуйлан
- “Техникийн лавлах шинэчлэх” – Оргил чанарын дугуйлан
- “Түүхий нүүрсний бункерийн отсос солих” - Эко чанарын дугуйлан
- “Ачааны лифтний тооромзны систем шинэчлэх” – Эрчим чанарын дугуйлан
- “Дренажийн бакны удирдлагыг сайжруулах” – Электрон чанарын дугуйлан
- “Төв барилгын шинэ ахуйн байранд агааржуулалтын схем хийх” – Урсгал чанарын дугуйлан гэх мэт.

2022 онд бүтээмж дээшлүүлэх кайзен саналын систем, энгийн сайжруулалтын ажлын систем, ажлын байрны соёл 5С, чанарын дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжиж ажилласнаар 66,113.0 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосноос гадна аюулгүй ажиллагааг дээшлүүлж, эрсдэлийг бууруулсан 29, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулсан 28, ажлын үйл явцыг хялбарчилсан 22, өртөг зардал бууруулсан 27 төслийг тус тус хэрэгжүүлсэн байна.

Хэрэгжүүлсэн төслийн тоо



“ДДЦС” ТӨХК нь жил бүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилладаг бөгөөд 2022 онд 26 заалт бүхий төлөвлөгөө гарган 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан.

2022 онд хийгдсэн ажлууд:

❖ ХАБЭА-н 1-р шатны үзлэг 5,041 удаа хийгдэж 5,392 илрүүлж 5,271 зөрчил устгасан. 2-р шатны үзлэг 162 удаа хийгдэж 147 зөрчил илрүүлж 132 бүрэн арилгасан. 3-р шатны үзлэгээр 4 удаа 146 зөрчил илрүүлж 143 зөрчил устгасан. Нийтдээ 5,546 зөрчлийг илрүүлж устгасан.

❖ Үйлдвэрлэлийн ажлын байруудад эрүүл ахуйн стандарт норм барьж ажиллах сайжруулалтын ажлууд хийгдсэн. Үүнд: Турбины машинч нарын ажлын байр ТГ-2,3,4 дээр вакум өрөөтэй болгосноор шуугиан 91дб-ээс 73дб болон буурсан. ЛК№4-ийн төгсгөлд их тоосрох нөхцөл бүрддэг. Үүнээс урьдчилан сэргийлж тоосыг буцааж хөөрөгдөн сорох хоолой шинээр хийж течикний хоёр талд лотокны хөшиг хийж уурын мананцрыг өгч тоосыг дотор нь чийгшүүлснээр тоос дэгдэлтийг багасгасан. 60 ажлын байранд гэрэлтүүлэг сэргээж, сайжруулах ажил хийгдсэн.

❖ 376 ширхэг гэрэл сэргээсэн байна. Ер нь худалдан авч буй гэрлийн чанар сайжирсан.

❖ Ажлын байрны бичил орчныг сайжруулах тал дээр компанийн удирдлагын зүгээс их анхаарч ажиллаж байна.

❖ Шинэ ажилтнуудын сургалт 2 удаа зохион байгуулж нийт 37 ажилтан хамрагдав. Нийт ажилтнуудад ХАБЭА-н талаар зөв ойлголт өгөх зорилгоор хууль, дүрэм журмыг сурталчлах 12 цагийн сургалтыг 5 болон 10-р сард 2 удаа зохион байгуулж нийт 963 ажилтан, ИТА-г хамруулж шалгалт авч баримтжуулав.

❖ Эрсдэлийн үнэлгээ хийх талаар танхимын сургалтыг 5 удаа хийсэнээс гадна 2 цахим хичээл хийж фэйсбүүк группт байршуулсанг 336/396 хүн үзсэн байна.

❖ АЭД-ыг компанийн хэмжээнд 4, системийн хэмжээнд 2, улирал бүр цех, алба хэлтсүүд ОЭД, ГЭД-ыг хийж, дасгалт хяналт тавьж, тайланг нэгтгэж танилцуулсан.

❖ Гагнуурчин, оосорлогч, дохиочин, кранчин, даралтат савтай харьцаж ажиллах эрх олгох сургалтуудад нийт 207 ажилтан хамрагдаж ИТА-д хамрагдаж эрхээ сунгуулав.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийг тодорхойлж үнэлэх нь байгууллагын стратеги шийдвэр гаргах төлөвлөлт хийх, үйл ажиллагаа, үйл явцыг чиглүүлэх, нөөцийг зөв хуваарилах үндэслэл болж, эрсдэлийг зөв зохистой удирдах нь байгууллагын зорилгодоо хүрэх магадлал боломжийг нэмэгдүүлдэг. Компани нь Мэдээллийн эрсдэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулан батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

✓ Компанийн эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг бий болгож гүйцэтгэх захирлын 2020 оны А-03 дугаар тушаалаар эрсдэлийн менежментийн хороо, эрсдэлийн үнэлгээний хороог байгуулсан.

✓ Эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх аргачлалыг ISO 31010 эрсдэлийн менежментийн стандарт шаардлагад үндэслэн боловсруулсан.

✓

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР

✓ 2022 онд байгууллагын байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны аудитын өгсөн зөвлөмжийн дагуу боловсруулж БОАЖЯ-аар батлуулж ажилласан. 2022.12.09-нд Дархан-Уул аймгийн БОАЖГ-т 2022 оны БОХМ-н төлөвлөгөөний биелэлтийн тайланг танилцуулж 96,2%-тай хамгаалсан.

Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийх ажлыг 2022.08.08-18-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Нийт 118 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж шалгахад 114 шалгуур бүрэн хангасан 1 шалгуур бүрэн бус, 3 шалгуур биелээгүй байна. Байгаль орчны аудитын ерөнхий дүнгээр 96,6% нь бүрэн биелэлттэй гэж дүгнэсэн.

✓ Агаарын бохирдлын хөндлөнгийн шинжилгээг 2022 оны 03-р сарын 23, 10-р сарын 11 өдрүүдэд хийлгэсэн. Агаарын бохирдлын шинжилгээний дүгнэлтээр хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/, нийт тоосонцор нь MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол гараагүй.

✓ Зуухнаас гарч байгаа утааны хийн хэмжилтийг сар бүр зуухан цехийн горимын инженер, техникч нараар хийлгэн ажиллаж байна. MNS5919;2008 стандартын дагуу TESTO350 багажаар хэмжилт хийж үр дүнг тооцож ажилласан. Утааны хийн найрлага дахь бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан тохиолдолгүй байна.

✓ Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг “УСНЫ ГАЗАР”-т ус ашигласан тайланг танилцуулан 2022 оны 02 дугаар сарын 01 өдөр ус ашиглах дүгнэлтийг гаргуулж, ХЕГСГ Захиргаатай усны дүгнэлтийн дагуу 2022 оны 02 дугаар сарын 10 өдөр **2,481,225м³** ус ашиглах гэрээг байгуулж ажилласан. 2022 оны ашигласан усны гүйцэтгэл **1,927,695м³** гарсан. Усны дүгнэлтээр өгсөн зөвшөөрлийн дүнгээс 22%-н хэмнэлттэй гарсан. Ашигласан усны төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулсан тооцоог нийлж усны тайланг танилцуулж, гэрээг дүгнүүлсэн. Гүний худгийн ашиглалт, ариун цэвэрт тавих хяналт, үзлэг, шалгалтыг улирал бүр хийж ажилласан.

✓ Аймгийн УЦУОШГ-аар хөрсний болон цацрагийн шинжилгээг жилд 2 удаа буюу 03-р сарын 12, 10-р сарын 10-ны өдрүүдэд хийлгэсэн.

❖ Үйлдвэрийн технологийн усны дотоодын шинжилгээг тогтсон хугацаанд Хими цехийн лабораториор тогтмол хийж байгаа бөгөөд хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд 2 удаа буюу 05-р сарын 25, 10-р сарын 11-ний өдрүүдэд УЦУОШГ-аар хийлгэхэд MNS0900:2018 “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан тохиолдол гараагүй.

❖ Аймгийн УЦУОШГ-аар хөрсний болон цацрагийн шинжилгээг жилд 2 удаа буюу 03-р сарын 12, 10-р сарын 10-ны өдрүүдэд хийлгэсэн. Гүний худаг, Мазутын бак, үйлдвэрийн яндангийн орчинд хийсэн хөрсний хими шинжилгээний дүгнэлтээр хөрсний эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэхэд MNS3297:2019 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй байсан.

❖ Орчны аюултай болон гамшигт үзэгдлийн түвшин Гамма цацраг идэвхийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 0,60 $\mu\text{Zv}/\text{цаг}$ байхаас үнсэн сангийн үнсэнд 0,11 $\mu\text{Zv}/\text{цаг}$ байгаа нь орчны аюултай болон гамшигт үзэгдлийн түвшин зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа болно.

❖ Монгол Улсын газрын тухай хуулийн 58.5-д газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулна гэж заасны дагуу газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг “Хос нахиа” ХХК-аар хийлгэж дүгнэлт, зөвлөмж гаргуулав.

❖ Монгол орон даяар өрнөж байгаа МОНГОЛ УЛС-ын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Дархан-Уул аймгийн засаг даргын санаачилсан “Ногоон Дархан 2032” хөдөлгөөнийг дэмжин Дархан-Уул аймгийн, Дархан сумын, Малчин багийн нутаг “Уужим булаг”-т Хараа голын эрэг дагуу 16000 ширхэг бургас модыг бүрэн тарьж дууссан. Дээрх ажлын хүрээнд 24 ажлуудыг төлөвлөн 100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.

Үйл ажиллагааны чиглэлээр:

2022 онд Хяналтын хэлтсийн зүгээс Удирдамжид шалгалтыг 2 удаа, графикт шалгалтыг 10 удаа, ХАБЭА-н 3-р шатны үзлэгийг 4 удаа, ээлжит бус үзлэгийг 10 удаа хийж нийт 675 зөрчил илрүүлэн 589 зөрчлийг бүрэн устгуулж, 86 зөрчлийг алба хэлтэс цехийн төлөвлөгөөнд тусгуулан устгах шатандаа явж байна. Зөрчил устгах албан шаардлагыг 15 удаа өгч зөрчлийг устгуулан хэрэгжилтийг шалгаж ажиллав. Өдөр тутмын үзлэгээр нийт 38 зөрчил илрүүлэн газар дээр нь устгуулж ажилласан.

✓ Аюул мэдээлэх хуудсаар 2021 онд 793 зөрчил илрүүлж 658-г устгаж байсан бол 2022 онд 1,143 зөрчил илрүүлж 1,044-г устгаж илрүүлэлт өмнөх оноос 31.6%-аар нэмэгдэж, зөрчил устгалт нь 2021 онд 82.9% байсан бол 2022 онд 91.0% болж өссөн байна.

✓ 2022 онд ажлын байрны бичил орчны хэмжилтийг сар бүр хийж ирсэн. Гэрэлтүүлэг 34.0лк-ээр сайжирсан, тоосжилт 1.45мг/м3-ээр буурч ажиллах нөхцөл сайжирсан. Шуугиан 2.9дб-ээр өссөн үзүүлэлттэй байгаа нь намар эрт тоноглол нэмэгдсэн холбоотой. ТГ-№2, 3, 4-ийн машинчийн ажлын байранд вакуум өрөөнүүд хийж өгч шуугиан, температурыг хэвийн нормд оруулж ажлын байрны нөхцөлийг сайжруулж, ажиллах таатай орчныг бүрдүүлж өгөв.

✓ 2022 онд тоног төхөөрөмжийн их урсгал засвар, гэмтэл устгалд нийт 1,521 ш наряд бичигдэж ямар нэгэн осол авааргүй хийж гүйцэтгэсэн байна. ТДЦ-3, Зуух-4, Турбин-5, Цахилгаан-2, Хими-3, ДХХ-А-1 технологийн карт боловсруулав. 51 ажлын байрны ажилбарын эрсдэлийн үнэлгээ хийгдэв.

✓ 2022 онд урьдчилсан зааварчилгааг нийт-390 анхан шатны зааварчилгааг нийт-205 ээлжит бус зааварчилгааг 8,783 ажилтанд тус тус өгсөн байна.

✓ Ээлжит зааварчилгаа: Сарын давтан – 5,325 ажилтанд, өдөр тутмын-74,756 ажилтанд, тухайлсан зааварчилгааг нийт – 4,943 ажилтанд тус тус өгсөн байна.

✓ **Ажилтны эрүүл мэндийн эрсдэл :**

Эрүүл мэндийн эрсдэл өндөртэй ажилтны биеийн байдлыг хянаж нарийн мэргэжлийн эмчийн хяналтад-21 ажилтан, В вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэлтэй 4 ажилтныг элэгний эмчийн хяналтад, зүрх судасны эмчийн хяналтад-13 ажилтныг оруулсан. Мөн чихрийн шижин өвчний илрүүлэлтийг давхардсан тоогоор 82 ажилтанд түргэвчилсэн тестээр хийж сахар өндөртэй 4 ажилтныг хэвтэн эмчлүүлсэн. Нурууны MRI хийлгэх 3 ажилтнаас 2 ажилтан шинжилгээ хийлгэж эмийн болон эмийн бус эмчилгээ хийлгэсэн. Хөдөлмөрийн нөхцөл солих 5 ажилтантай уулзах уулзалтыг хэлтсийн даргатай болон ар гэртэй нь хамтран уулзалт хийж Нэгдсэн эмнэлгийн хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр оруулах гэсэн боловч хөдөлмөрийн нөхцөл солих заалттай онош заагдаагүй учраас ажил хөдөлмөрийн нөхцөл сольсон ажилтан байхгүй. Эрүүл мэндийн эрсдэл өндөр 2 ажилтныг 3-р шатлалын эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн.

Ковид-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тухай бүр Эрүүл мэндийн газар болон ЭХЯ-д мэдээ тайланг өгч, аймгийн онцгой комиссын шийдвэрийг мөрдөж ажиллаж ирсэн ба халдварын шинж тэмдэг илэрсэн ажилтнуудыг түргэвчилсэн шинжилгээнд хамруулж батлагдсан тохиолдлыг эмчлүүлсэн. Мөн Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн газраас өгсөн зөвлөмжийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх дадал хэвшил бий болго зорилгоор нийт ажилтнуудад амны хаалт, гар ариутгагч зэргийг компаниас хангаж, мөн мэдээ мэдээлэл, зөвлөмж зөвлөгөөг мэдээ мэдээллийн самбарууд болон байгууллагын дотоод сүлжээгээр дамжуулан хүргэн ажилласан.

Тоног төхөөрөмжийн эрсдэл:

✓ Дотоодын мэдлийн даралтат сав шугам хоолой: 2022 онд графикийн дагуу 8 тоноглолд техникийн магадлал хийлгэж ашиглах эрхийг сунгуулав. Хими цехийн 4 шүүлтүүрүүдэд металлын шинжилгээ,

техникийн магадлал хийх график гарган хэрэгжүүлсэн.

Турбин цехийн деаратор, дренажын бак, 8/13, 1,2 ата уурын коллекторуудад гадаад дотоод үзлэг, техникийн магадлал хийж ажлын даралтад ажиллах зөвшөөрлийг өгөв. Бүрэн зогсолтоор тус коллекторуудад Эрчим хүчний хөгжлийн төвөөс металлын бүтцийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулав.

3. Улсын бүртгэлтэй даралтат сав:

Улсын бүртгэлтэй даралтат сав болох Зуух-№1,4, Зуух-№1,3,6,7,8-ын тэжээлийн усны шугам, ПВД-№1аб, Заб, 7, 9, ҮБ-№3, 4, 5, ТБ-№2, 3-д ээлжит техникийн магадлалыг улсын байцаагчийг байлцуулан хийлгэж ашиглах эрх сунгуулсан. Зуух-№1-9-н хурц уурын шугамуудад гадаад дотоод үзлэг хийлгэсэн. Тэжээлийн усны шугам хоолойн их засварын дараах ээлжит бус техникийн магадлалыг улсын байцаагчийг байлцуулан хийлгэж ашиглах эрх сунгуулсан.

4. Хэмжил зүй: 2022 онд ДХХ-А, цахилгаан цехүүдийн хэмжих хэрэгсэл, хамгаалалтын багажуудын баталгаажуулалтын ажил графикийн дагуу хийгдэж байгаа эсэхэд 2 удаа хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг устгуулсан. ДХХ-А цехийн мөнгөн тооцоот-15, дотооддоо 147 хэмжүүр баталгаажуулсан.

5. Улсын бүртгэлтэй 8 өргөх зөөх механизм байна:

Зуухан цехийн 2ш, турбин цехийн 1ш гүүрэн краны ээлжит хэсэгчилсэн магадлалыг хийлгэсэн. Зуухан цехийн 25 тн-н 4 салаа тэнжээ шаардлага хангахгүй байсныг шинээр сольж дүрмийн шаардлагад нийцүүлэв.

6. Дотоодын мэдлийн өргөх зөөх механизм:

Дотоодын мэдлийн 101 цахилгаан болон гар тайл, леботка, ган болон даавуун татлага, хаягдал хог зөөх сав 9, хамгаалах бүс 50 байгааг 2022 онд туршилт хийж комиссын шийдвэрээр ашиглах зөвшөөрөл олгосон.

САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ

Тухайн компани нь үндсэн үйл ажиллагааны орлогоороо зардлаа санхүүжүүлж чадахгүй болох процессыг хэлнэ.

Хөрвөх чадварын эрсдэл

Нүүрсний уурхайнууд болон засвар үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж сэлбэг материал нийлүүлсэн компаниудад төлөх төлбөр нэхэмжилснээр зайлшгүй өөр зээлийн санхүүжилт төвлөрүүлэх эсвэл активаа зарахад хүргэж байна.

Төлбөрийн чадварын эрсдэл

Компанийн хувьд Эрчим хүчний зохицуулах хорооноос тариф бууруулах, оновчтой горимд ажиллахгүй нөхцөлд нэг буюу хэд хэдэн эрсдэлийн улмаас үүссэн алдагдлыг компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлэгчийн хөрөнгийн нөөц хангаж чадахгүй болсноор эрсдэл үүсэж байна.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн үнэ ханш нийгэм, улс төр, олон улсын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байдаг. Зээлийн хүүгийн түвшин, валютын ханш, барааны үнийн өөрчлөлтөөс хамаарч компани эрсдэлд орж байна.

Худалдан авах чадварын эрсдэл

ЭХЗХ-оос үнэ тариф нэмэгдүүлэхгүй байх, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түгээлт тасрах үед орлого буурч их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтаар авах тоног төхөөрөмж сэлбэг материалаа худалдаж авах чадамжгүй болж байна.

Зээлийн эрсдэл

Компанийн актив дахь хөрөнгө хугацаандаа бүрэн орж ирэхгүй орлого төвлөрүүлэлт муу байгаагаас зээлийн эрсдэлд орж байна.

Инфляцийн эрсдэл

Инфляци өндөр буюу сэлбэг материал, түүхий эдийн үнэ өсөж байгаа үед хөрөнгө оруулалтын өгөөж, ашгийн хувь хэмжээ инфляцийн түвшингээс доогуур орж эрсдэл үүсэж байна.

Валютын ханшны эрсдэл

Валютын эх үүсвэр татах, валютаар хөрөнгө оруулалт хийх, гадаад төлбөр тооцоо хийх зэргээс үүсдэг гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлүүд бий болж байна.

Дээрх эрсдэлүүд үүссэнтэй холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлж авсан арга зам нь ЭХЗХ-оос тогтоосон үнэ тарифт багтаан төлөвлөх, техник эдийн засгийн урт хугацааны төлөвлөгөөнд тулгуурлан хийгдэх ажлуудаа эрсдэлээр нь эрэмбэлэн үр ашиг нэмэгдүүлж, зардал хэмнэсэн тоног төхөөрөмж, сэлбэг бараа материал худалдаж авах, их засварын чанарыг улам сайжруулах, бусад үйл ажиллагаанаас орлого олох, үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдүүлэх зэрэг олон олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

“ДДЦС” ТӨХК нь Монгол улсын Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай, Авлигатай тэмцэх тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу “Компанийн үйл ажиллагааны нээлттэй мэдээллийг боловсруулах, цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам”-ыг гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулснаар нийт 26 төрлийн мэдээллийг оруулан ажилласан. Мөн Сангийн ямаар батлуулсан Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn/>, төлөвлөгөөний биелэлт болон тендер шалгаруулалтын зар, урилга, үр дүнг, хуулийн дагуу tender.gov.mn/, <http://shilendans.gov.mn> сайтуудаар цаг тухай бүрд нь мэдээлж ажилласан.

Олон нийтийн сүлжээ

2022 онд үйл ажиллагааны болон шагнал гардуулах арга хэмжээний фото зураг авч 17 мэдээлэл, харуулын ПОСТ №1-т байрлах самбарын ХАБЭА-н сар бүрийн шилдэг ажилтнуудын зургийг хамт олонд таниулж алдаршуулах ажлыг зохион байгуулсан. Компанийн нийт ажилтнуудыг хамарсан станцын бүрэн зогсолтын мэдээлэл, 10 нээлттэй ажлын байрны зарлал болон цаг үетэй холбоотой бусад мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулсан.

Компанийн цахим хуудас

Компанийн цахим хуудсанд нийтэд дараах мэдээллүүдийг ил тод, нээлттэй мэдээлдэг. Үүнд:

- ✓ Компанийн танилцуулга, ТУЗ-ийн гишүүд, удирдлагын танилцуулга, Компанийн бүтэц зохион байгуулалтын схем, тухайн жилийн зорилт
- ✓ Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн тогтоол, шийдвэрүүд
- ✓ Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
- ✓ Компанийн үйл ажиллагааны тайлан, техник, технологийн шинэчлэл, хэрэгжүүлсэн болон хэрэгжиж байгаа төслүүд, цаг үеийн мэдээлэл, чанар бүтээмжтэй холбоотой мэдээ, мэдээллүүд
- ✓ Компанийн стратеги төлөвлөгөө, зорилтот түвшний мэдээлэл, Компанийн нууцад хамаарахгүй дүрэм, журмууд
- ✓ Нээлттэй ажлын байрны зар мэдээлэл

Компанийн цахим хуудсанд дахь компанийн талаарх мэдээллээр дамжуулан иргэд, байгууллага манай Компанийн талаар тодорхой мэдээлэл авах боломжтой. Мөн цахим хуудасны доод хэсэгт холбоо барих утас, факсын дугаар, цахим шуудан, facebook хуудасны хаягийг байрлуулснаар цахим хуудсанд зочлогсод сонирхсон асуудлаа тодруулах боломжтой.

2022 онд:

- ✓ Үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл 31, Бүтээмж чанарын талаарх мэдээлэл 9, Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэр 39 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр 4, 2021 оны аудитын тайлан, 2022 оны 1-4 улирлын санхүүгийн тайлан, 2022 оны зорилтот түвшний мэдээллүүдийг тус тус байрлуулсан.
- ✓ Удирдлагын багийн танилцуулга, бүтцийн схем, шинэчлэгдэж батлагдсан дүрэм, журмуудыг шинэчилж байрлуулсан.

ДОТООД АУДИТ

Санхүүгийн хяналт:

- Компанийн санхүүгийн дотоод хяналт шалгалтыг давхардсан тоогоор 27 удаа явуулж 14 зөрчил илрүүлж залруулсан. 2022 онд санхүүгийн анхан шатны бичиг баримт, кассын орлого зарлага, үлдэгдэлд хяналтын тооллогыг 4 удаа хийж 13 зөрчил илрүүлж зөвлөмж өгч устгуулсан.

- 2022 онд төрийн өмчийн улсын үзлэгээр хяналтын тооллогыг нийт 6 дээр түүврийн аргаар 8,026,590,025.7 төгрөгийн үлдэх өртөг бүхий 307 нэр төрлийн эд хөрөнгийг тоолов. 2021 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор актлахаар санал оруулсан хөрөнгийн бодит байдалд хяналт хийж тулган баталгаажуулав.

- Шилэн дансаар 12 удаа хяналт хийхэд 21 төрлөөр 155 мэдээлэл оруулж 12 сарын байдлаар зөрчилгүй байна.

- Дархан-Уул аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас компанийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр хийх ажлын төлөвлөгөөний биелэлт, Дархан-Уул аймаг дахь төрийн аудитын газраас компанийн 2019-2021 оны үйл ажиллагааны үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд удирдамжид хяналт хийсэн.

- Монгол улсын үндэсний аудитын газрын захиалгаар “Эвиденсе аудит” ХХК 2021 оны санхүүгийн тайланд аудит хийж 3 зөвлөмж, 2 албан шаардлага өгч биелэлтэд хяналт тавьж ажилласан. Биелэлт 100%

- Аюулгүйн нөөцийн бүрдэл, нөхөн бүрдүүлэлт, ашиглалтад хийсэн хяналтаар 102 нэр төрлийн бараа, сэлбэг материал байхаас 29 нэр төрлийн сэлбэг байхгүй 3 нэр төрөл нь тоо ширхэг дутуу, бүрдүүлэлт 71.5% байсан тул 2023 оны ХАА-ны төлөвлөгөөнд тусгуулсан.


- Худалдан авалтын төлөвлөгөө, биелэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn/>, <http://shilendans.gov.mn/> сайтуудаар цаг тухай бүрд нь мэдээлж зөрчил, хоцролт гараагүй байна.

- 2022 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 170 нэр төрлийн 13,199.2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө боловсруулан ажилласнаас 168 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг 12,512.5 сая төгрөгийн худалдан авалтыг амжилттай зохион явуулсан ба 98.8%-ийн гүйцэтгэлтэй байна.

2022 онд гэрээний дагуу нийлүүлэгдэж байгаа сэлбэг материалыг компанийн хашаанд орохоос нь өмнө хүлээж авах комисстой хамтран үзлэг шалгалтыг 8 удаа хийж техникийн шаардлага хангасан байдалд дүгнэлт гарган акт үйлдэж ажилласан.


ХҮНИЙ НӨӨЦ

“ Дарханы Дулааны Цахилгааны Станц” ТӨХК-ийн бүтэц,
зохион байгуулалт



Хүний нөөцийн талаар:

• “ДДЦС” нь хүний нөөцийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулахад чадварлаг, бүтээмжтэй, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах бодлого баримтлан 2019 оноос 2030 он хүртэл баримтлах “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг батлан хэрэгжүүлж байна. 2022 оноос эхлэн хэрэгжиж буй “Хөдөлмөрийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд ажилтан бүртэй хийх хөдөлмөрийн гэрээг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын хавсралтад нийцүүлэн шинэчлэн байгуулсан.




Манай компанид зөвлөх инженер 6, мэргэшсэн инженер 11, техникийн ухааны магистр 34, мэргэшсэн нягтлан бодогч-1, тэргүүлэх төсөвчин-4, бакалавр зэрэгтэй 179 ажилтан ажиллаж байна. Ажилтнуудыг насны ангиллаар нь тодорхойлбол: 18-30 нас-17 хувь, 31-50 нас-72 хувь, 50 наснаас дээш-11 хувь, боловсролын хувьд дээд боловсролтой -44 хувь, тусгай дунд-6 хувь, бүрэн дунд боловсролтой -50 хувийг тус тус эзэлж байна.

Компанийн ажилтнуудад хууль, эрхзүйн мэдээлэл өгөх, удирдах ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх хүрээнд 2 удаагийн хөтөлбөрт сургалтыг зохион байгуулж ажилласан. 2022 онд нийт 43 ажилтантай “Багш, шавийн гэрээ” байгуулж нийт 2,6 сая төгрөгийн урамшуулал олгосон. Компанийн хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн Нийгэм, эдийн засгийн байдал, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан нэмэгдэж тогтворгүй байдлын коэффициент 6.82 болж өмнөх оноос 4.14 нэгжээр нэмэгдсэн.


Хүний нөөцийн удирдлагын программ хангамж болох HR болон ABLE программ ашигласнаар тухайн ажилтнуудын мэдээллийг хадгалах, инженер техникийн ажилтнуудын тухайн жилийн зорилт болон үүрэг даалгаврыг бүртгэн дүгнэж нэгдсэн биелэлтийг гаргаж удирдлагуудад танилцуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулан ажилласан.

ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, ЦАЛИН ХӨЛС

"ДДЦС" ТӨХК-ийн ажиллагсадын цалин нэмэгдүүлсэн талаарх судалгаа



"ДДЦС"ТӨХК-н Дундаж цалин / төг /



КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Ажилтнуудад чиглэсэн:

2022 онд компанийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны болон хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх зорилгоор 9 бүлэг 101 заалт бүхий Хамтын гэрээг Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулан бүрэн биелүүлж ажилласан.

2022 оны жилийн эцсийн байдлаар ажилтнуудын нийгмийн зардалд нийт 861.4 сая төгрөг зарцуулсан бөгөөд энэ нь компанийн нийт зардлын 2 хувийг эзэлж байна. Компанийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 57.2 сая төгрөг зарцуулсан. Мөн 37 ахмадад 22.4 сая төгрөг, 29 ажилтанд 40.2 сая төгрөгийн буцалтгүй тусламж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 14 ажилтанд 397.1 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, амралт сувиллын хөнгөлөлтөд 4 ажилтан 1 ахмадад 1.18 сая төгрөг тус тус олгосон.

Манай компани ажилтнуудаа орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд 2013 оноос эхлэн орон сууцны дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд 2021 онд 12 ажилтанд нийт 108 сая төгрөгийн орон сууцны дэмжлэгийг олгосон бөгөөд 2022 онд сайдын шийдвэрээр орон сууцны дэмжлэгийг хөрөнгийг хассан.

Гадагшаа чиглэсэн:

Энэ онд ажилтнуудаас сайн дурын хандив цуглуулж нийт 9 иргэнд хандивласан. Үүнээс: Компанийн гүйцэтгэх захирал асан О.Нямдаваагийн эмчилгээнд 13.9 сая, үйлдвэрлэлийн осолд өртсөн тогооч Д. Мөнх-Намуунд 5.715 сая, хүүхдээ асрах чөлөөтэй байгаа М.Энхцолмонгийн хүүхдийн эмчилгээнд 8.2 сая, Итгэл найдвар бэлэглэх 1000 төгрөгийн хандивт 585.0 мянган төгрөг, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн инженер Г.Ганхуягийн дүүгийн хорт хавдрын эмчилгээнд 4.3 сая, Турбин цехийн ажилтан Б.Үнэнхүүгийн эмээгийнх нь байшин бүрэн шатсан тул 3.57 сая, Түлш дамжуулах цехийн ажилтан Л.Баасанжаргалын дүүгийн хорт хавдрын эмчилгээнд 3.2 сая, их эмч А.Саулегулын дүүгийн хорт хавдрын эмчилгээнд 2.5 сая, Зуухны машинч Э.Нэргүйд ээжийнх нь эмчилгээнд зориулан 3.9 сая төгрөгийг тус тус хандивласан. 2022 онд нийт 45.9 сая төгрөгийн сайн дурын хандивыг ажилтнууд цуглуулж өгсөн.

Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран ойн нэн ховор туруутан амьтдын гол тархац газруудад биотехникийн арга хэмжээ авах ажлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.

Уламжлалт энэ ажлыг 2022.02.25-26-ны өдрүүдэд Хонгор сумын 2-р багийн нутаг Мөөл уул, Мухарын гол, Моностой гэх газруудын 6 марааны цэгт 1,000 кг хужир байршуулж биотехникийн арга хэмжээг авч хамтран ажилласан. Шинээр 3 марааны цэг байгуулсан.

Дархан-Уул аймгийн Дархан сумын Малчин багийн нутаг Хараа гол дагуу хог хаягдлыг цэвэрлэх цэвэрлэгээний ажлыг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж компанийн 20 гаруй ажилтан оролцов. Нийт 3 ачааны машин хогийг ачиж хогийн цэгт буулгасан.



Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2022 оны 04 дугаар сарын 22-ны 23/90 тоот албан мэдэгдлийн дагуу компанийн ажилтнууд шаардлагатай техник хэрэгслийн хамт 2022 оны 4 дүгээр сарын 28, 29, 30-ны өдрүүд, 05 дугаар сарын 10, 11, 12, 13-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Дархан сумын 15-р багийн нутаг дэвсгэр дэх үерийн усны хамгаалалтын барилга, байгууламжийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ ажлыг нийт 5 техник, 20 хүний бүрэлдэхүүнтэй ажлын бригад гарч 21 ширхэг далангийн хавтанг сэргээн засварлаж, 4,158 м урт үерийн далангийн хог, шороог цэвэрлэн 7 автомашин хог ачиж хогийн цэгт асгасан.



Монгол орон даяар өрнөж байгаа Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн нэгдэж Дархан-Уул аймгийн, Дархан сумын Малчин багийн нутаг "Уужим булаг"-т Хараа голын эрэг дагуу 16,000 ширхэг бургас модыг бүрэн тарьсан.





2022 оны 04 сард Дархан-Уул аймгийн Миний монгол цэцэрлэгт хүрээлэнд манай компани байгуулж тохижуулсан Хилэнцийн ордыг сэргээн засварлах ажил гүйцэтгэлээ. Уг ажлын хүрээнд тоглоомуудыг засаж сэлбэх, будаж сэргээх ажлыг гүйцэтгэв.



2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН	31
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	31
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	32
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	33
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	34
ҮЛДЭГДЭЛ ТЭНЦЛИЙН ТАЛААР	35
АВЛАГЫН ТАЛААР	35
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ	36
БАРАА МАТЕРИАЛ	36
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР	36
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	37
ЭЗДИЙН ӨМЧ, ХУРИМТЛАГДСАН АШИГ, АЛДАГДЛЫН ТАЛААР	38
НИЙТ ОРЛОГО	38
НИЙТ ЗАРДАЛ	39

“ДДЦС” ТӨХК-ийн төрийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад бүртгэлээр хяналт тавьж, санхүү эдийн засгийн ойрын болон хэтийн бодлогыг тодорхойлон төлөвлөж түүний гүйцэтгэлийг ханган биелүүлэх замаар компанийг ашигтай ажиллуулах чиглэл баримтлан ажилласан. Санхүү бүртгэлийн тайлан тэнцлийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн гаргаж аудитаар баталгаажуулсан. Компанийн хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилласан.

"Дарханы ДЦС" ТӨХК

Санхүү байдлын тайлан

Тайлант үе: 2022/01/01 - 2022/12/31

/төгрөгөөр/

Мэргийн н	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
1	ХӨРӨНГӨ				
1.1	Эргэлтийн хөрөнгө				
1.1.1	Мөнгө гүүнтэй адилгах хөрөнгө	196,603,394.52	120,752,146.97	-75,851,247.55	0.07
1.1.2	Дансны авлага	6,118,603,971.26	2,993,461,142.84	-3,125,142,828.42	1.72
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	405,422,444.28	772,516,021.61	367,093,577.33	0.44
1.1.4	Бусад авлага	203,787,126.58	254,915,666.35	51,128,539.77	0.15
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00		
1.1.6	Бараа материал	3,593,931,850.05	5,319,307,144.77	1,725,375,294.72	3.06
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	562,136,551.23	666,021,528.47	103,884,977.24	0.38
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,080,485,337.92	10,126,973,651.01	-953,511,686.91	5.83
1.2	Эргэлтийн бус хөрөнгө			0.00	
1.2.1	Үндсэн хөрөнгө	145,629,531,329.04	138,980,364,957.01	-6,649,166,372.03	80.03
1.2.2	Биет бус хөрөнгө	24,883,347,937.87	24,553,601,063.35	-329,746,874.52	14.14
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	170,512,879,266.91	163,533,966,020.36	-6,978,913,246.55	94.17
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	181,593,364,604.83	173,660,939,671.37	-7,932,424,933.46	100.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
2.1	ӨР ТӨЛБӨР				
2.1.1	Богино хугацаат өр төлбөр				
2.1.1.1	Дансны өглөг	3,845,292,536.14	7,547,826,968.41	3,702,534,432.27	4.35
2.1.1.2	Цалингийн өглөг	376,653,856.00	464,458,456.00	87,804,600.00	0.27
2.1.1.3	Татварын өр	1,288,443,854.17	568,266,604.10	-720,177,250.07	0.33
2.1.1.4	НДШ-ийн өглөг	852,278,486.36	0.00	-852,278,486.36	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	835,862,778.07	0.00	-835,862,778.07	0.00
2.1.1.8	Хойшлогдсон орлого	594,421,970.20	0.00	-594,421,970.20	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	9,844,725.38	0.00	-9,844,725.38	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,802,798,206.32	8,580,552,028.51	777,753,822.19	4.94
2.1.2	Урт хугацаат өр төлбөр				
2.1.2.1	Урт хугацаат зээл	69,796,045,609.02	78,843,610,402.20	9,047,564,793.18	45.40
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	12,483,947,125.35	3,493,125,405.57	-8,990,821,719.78	2.01
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	82,279,992,734.37	82,336,735,807.77	56,743,073.40	47.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	90,082,790,940.69	90,917,287,836.28	834,496,895.59	52.35
2.3	Эздийн өмч				
2.3.1	Төрийн өмч	10,040,100,005.47	10,040,100,005.47		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний хөрөнгө	72,035,033,589.81	71,992,043,066.58	-42,990,523.23	41.46
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	22,603,140,000.00	22,603,140,000.00	0.00	13.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-13,167,699,931.14	-21,891,631,236.96	-8,723,931,305.82	-12.61
2.3.11	Эздийн өмчийн дүн	91,510,573,664.14	82,743,651,835.09	-8,766,921,829.05	47.65
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	181,593,364,604.83	173,660,939,671.37	-7,932,424,933.46	100.00

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯ-БО



/М. ЖАРГАЛСАЙХАН/

/Ц.УУГАНБАЯР/

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант үе:

2022/01/01 - 2022/12/31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн	зөрүү
1	Борлуулалтын орлого (цэвэр)	50,808,096,868.24	53,920,465,545.64	3,112,368,677.40
2	Борлуулалтын өртөг	50,841,127,519.04	58,681,888,336.90	7,840,760,817.86
3	Нийт ашиг (алдагдал)	-33,030,650.80	-4,761,422,791.26	-4,728,392,140.46
4	Түрээсийн орлого	0.00	0.00	
5	Хүүгийн орлого	74,666.30	0.00	-74,666.30
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00	
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00	
8	Бусад орлого	1,437,713,182.01	10,286,025,449.74	8,848,312,267.73
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	999,876,869.43	942,278,692.48	-57,598,176.95
11	Санхүүгийн зардал	199,191,020.56	19,365,197.45	-179,825,823.11
12	Бусад зардал	3,410,215,190.73	3,513,224,636.22	103,009,445.49
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	5,573,198,911.75	-9,342,134,976.25	-14,915,333,888.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,930,980.46	42,989,538.26	39,058,557.80
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00	
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00	
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,372,604,009.00	-8,249,411,305.66	-10,622,015,314.66
19	Орлогын татварын зардал	7,466.63	0.16	-7,466.47
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,372,596,542.37	-8,249,411,305.82	-10,622,007,848.19
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00	
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,372,596,542.37	-8,249,411,305.82	-10,622,007,848.19
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00	
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00	
24	Орлогын нийт дүн	2,372,596,542.37	-8,249,411,305.82	-10,622,007,848.19
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00	

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯ-БО



/М. ЖАРГАЛСАЙХАН/

/Ц.УУГАНБАЯР/

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайланг үе: 2022/01/01 - 2022/12/31

	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	32,643,240,005.47	0.00	0.00	72,035,560,054.37	0.00	-15,540,296,473.51	89,138,503,586.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	32,643,240,005.47	0.00	0.00	72,035,560,054.37	0.00	-15,540,296,473.51	89,138,503,586.33
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	-22,603,140,000.00	0.00	0.00	0.00	22,603,140,000.00	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	2,372,596,542.37	2,372,596,542.37
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	-526,464.56	0.00	0.00	-526,464.56
9	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,040,100,005.47	0.00	0.00	72,035,033,589.81	22,603,140,000.00	-13,167,699,931.14	91,510,573,664.14
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	10,040,100,005.47	0.00	0.00	72,035,033,589.81	22,603,140,000.00	-13,167,699,931.14	91,510,573,664.14
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	-474,520,000.00	-474,520,000.00
15	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	-8,249,411,305.82	-8,249,411,305.82
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	-42,990,523.23	0.00	0.00	-42,990,523.23
17	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,040,100,005.47	0.00	0.00	71,992,043,066.58	22,603,140,000.00	-21,891,631,236.96	82,743,651,835.09

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ НЯ-БО



/М. ЖАРГАЛСАЙХАН/
/Ц.УУГАНБАЯР/

Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант үе:

2022/01/01 - 2022/12/31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	51,423,996,681.43	51,423,996,681.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	51,045,548,950.56	51,045,548,950.56
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	378,447,730.87	378,447,730.87
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	49,453,702,810.62	49,453,702,810.62
1.2.1	Ажиллагчдад төлсөн	10,725,542,565.05	10,725,542,565.05
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,323,300,000.00	3,323,300,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	13,004,790,448.84	13,004,790,448.84
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	18,308,434,569.98	18,308,434,569.98
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	30,087,378.00	30,087,378.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,022,140,495.47	4,022,140,495.47
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	39,407,353.28	39,407,353.28
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,970,293,870.81	1,970,293,870.81
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	700,976,829.15	700,976,829.15
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	700,976,829.15	700,976,829.15
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн	-700,976,829.15	-700,976,829.15
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,361,208,445.09	2,361,208,445.09
3.1.1	Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,358,735,609.00	2,358,735,609.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,472,836.09	2,472,836.09
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,706,376,734.30	3,706,376,734.30
3.2.1	Зээл, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн	3,231,249,759.76	3,231,249,759.76
3.2.2	Санхүүгийн гүрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	474,520,000.00	474,520,000.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	606,974.54	606,974.54
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	-1,345,168,289.21	-1,345,168,289.21
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-75,851,247.55	-75,851,247.55
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	196,603,394.52	196,603,394.52
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,752,146.97	120,752,146.97

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯ-БО



/М. ЖАРГАЛСАЙХАН/



/Ц.УУГАНБАЯР/

ҮЛДЭГДЭЛ ТЭНЦЛИЙН ТАЛААР

Хөрөнгийн талаар

2022 оны эхэнд нийт хөрөнгө 181,593.4 сая төгрөг, оны эцэст 173,660.9 сая төгрөг болж, 7,932.4 сая төгрөгөөр буурсан. Энэ нь Эргэлтийн хөрөнгө дотор авлага 2,706.9 сая төгрөгөөр буурсантай холбоотой. Эргэлтийн бус хөрөнгө дотор үндсэн хөрөнгө 6,978.9 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн.

Хөрөнгийн 163,534.0 сая төгрөг буюу 94,17 хувь нь эргэлтийн бус хөрөнгө, 10,126.9 сая төгрөг буюу 5,83 хувь нь эргэлтийн хөрөнгө тус тус эзэлж байна.



АВЛАГЫН ТАЛААР

- ✓ Нийт авлага оны эхэнд 6,727.3 сая төгрөг байснаас оны эцэст 4,020.9 сая төгрөг болж өмнөх оноос 2,706.4 сая төгрөг буюу 40.2 хувиар буурсан. 2022 оны зорилтот түвшнээс 805.9 сая төгрөг буюу 25 хувиар өссөн.
- ✓ Борлуулалтын авлага оны эхэнд 6,118.6 сая төгрөгөөс 2022 онд 2,993.5 сая төгрөг болж 3,125.1 сая төгрөг буюу 51.1% буурсан.
- ✓ Үүнээс: "ДҮТ" ТӨХК буюу нэг худалдан авагчаас авах цахилгааны авлага оны эхэнд 5,807.7 сая төгрөгөөс 2,837.1 сая төгрөг болж 2,970.6 сая төгрөг буюу 51.1% буурсан.
- ✓ "ДДС" ТӨХК-аас авах дулааны авлага 310.9 сая төгрөгөөс 156.3 сая төгрөг болж 154.6 сая төгрөг буюу 49.7% буурсан.
- ✓ Бусад авлага оны эхэнд 608.7 сая төгрөг байснаас 1,027.4 сая төгрөг болж 418.7 сая төгрөгөөр өссөн.



УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

2022 онд урьдчилж төлсөн тооцоо 562.1 сая төгрөг байснаас 666.0 сая төгрөг болж, 103.9 сая төгрөгөөр өссөн нь Төмөр замд “ДҮТ” ТӨХХК-аас 42.6 сая төгрөгийн хаалт илүү өгсөнтэй холбоотой.

БАРАА МАТЕРИАЛ

Тайлант оны эцсээр бараа материалын зардал 5,319.3 сая төгрөг болж 1,725.4 сая төгрөгөөр өссөн. Нүүрс, мазут 350.5 сая төгрөг, сэлбэг 1,013.4 сая төгрөг нь зуух №3-ын их засварын тендерт оролцогч ороогүйгээс шалтгаалан хойшлогдон оны эцэст шалгарч материал нь нийлүүлэгдэн зарцуулагдаагүй үлдсэн. Химийн материал 103.5 сая төгрөгөөр, шатахуун, хүнсний материалын үнийн өсөлтөөр тус тус өссөн.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ


2022 оны эцэст 373,848.2 сая төгрөгийн балансын үнэтэй, 210,314.3 сая төгрөгийн элэгдэл бүхий үндсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явууллаа.

2022 онд хөрөнгө оруулалтаар 1,083.7 сая төгрөгийн, техник зохион байгуулалтын арга хэмжээ, их засварын ажлын хүрээнд 4,605.8 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэв.

Ашиглалтын шаардлага хангахгүй, элэгдлээ нөхсөн 152.6 сая төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хасав. Нийт үндсэн хөрөнгийг эзлэх хувь хэмжээгээр нь харуулбал:

Барилга байгууламж	21.6%
Тавилга эд хогшил	0.3%
Машин тоног төхөөрөмж	70.4%
Тээврийн хэрэгсэл	0.8%
Биет бус хөрөнгө	0.9%
Бусад хөрөнгө	0.01%
Газар эзэмших эрх	6.0%

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ




ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Богино хугацаат өглөг оны эхэнд 7,802.8 сая төгрөг байснаас 8,580.5 сая төгрөг болж өссөн. Оны эхнээс 777.7 сая төгрөгөөр өссөн. Үүнд: Татвар, НДШ-ийн өрийг 1,572.4 сая төгрөгөөр бууруулж, банкны зээл болон бусад өр төлбөрийг бүрэн барагдуулсан. Нүүрсний үнийн өсөлт болон, үйлдвэрлэлийн өсөлтөөс шалтгаалсан илүү худалдан авалтаас шалтгаалан нүүрсний өглөг урд оны мөн үеэс 960.8 сая төгрөгөөр өссөн. Богино хугацаат өр төлбөрийн бүтцийг сүүлийн 3 жилээр харвал:

Өр төлбөрийн ангилал	2020	2021	2022	Хувь
Нүүрсний өглөг	738.4	1,722.7	2,683.5	31.3%
Татвар, НДШ-ийн өглөг	2,450.4	2,140.7	568.3	6.6%
Цалингийн өглөг	393.5	376.6	464.5	5.4%
Зээл, зээлийн хүүгийн өглөг	1,230.2	835.9	0	0.0%
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх өглөг	3,233.2	2,114.9	4,864.2	56.7%
Бусад өглөг	203.1	612.0	0	0.0%
Богино хугацаат өглөгийн дүн	8,248.8	7,802.8	8,580.5	100%

УРТ ХУГАЦААТ ӨР


2022 оны эцэст 82,336.7 сая төгрөгийн урт хугацаат өртэй үүнээс урт хугацаат зээлийн өр 73,819.2 сая, хуримтлагдсан зээлийн хүүгийн өр 5,024.4 сая, хойшлогдсон орлого 3,493.1 сая төгрөг. Төслөөр хэрэгжсэн 6 зээлийн өртэй байна. 1994-2010 онд хэрэгжиж дууссан төслийн 5 зээлийн өр нь оны эхэнд 1,750.1 сая төгрөг байснаас 1,551.0 сая төгрөг болж буурсан. Эдгээр 5 зээлийн тайлант үеийн үндсэн зээл ба хүүгийн төлбөрийг графикайн дагуу цаг хугацаанд нь төлж ажилласан. 35МВт-аар өргөтгөхөөр ХБНГУ-ын KFW банкнаас авсан ТГ№5 төслийн зээлийн өр 2022 оны эцэст 19.7 сая евро буюу 72,268.2 сая төгрөг, үүнээс төлөгдөөгүй хуримтлагдсан зээлийн өр нь 1.45 сая евро буюу 5,308.6 сая төгрөг. Уг төслийн хуримтлагдсан зээлийн хүүгийн өр 1.37 сая евро буюу 5,024.4 сая төгрөг. Еврогийн зээлийн өр 2022 онд валютын ханшийн өсөлтөөс 9,346.8 сая төгрөгөөр өссөн. Урт хугацаат өглөгийн бүтцийг сүүлийн 3 жилээр харуулбал:



ЭЗДИЙН ӨМЧ, ХУРИМТЛАГДСАН АШИГ, АЛДАГДЛЫН ТАЛААР

2022 онд Дахин үнэлгээний нэмэгдэл 72,035.0 сая төгрөг байснаас 71,992.0 сая төгрөг болж, 43.0 сая төгрөгөөр буурсан. Акталсан, данснаас хассан хөрөнгийн хэрэгжилт тооцогдсон. Төрийн өмчийн хөрөнгө 10,040.1 сая төгрөг, газар эзэмших эрх 22,603.14 сая төгрөг тус тус хөдөлгөөн гараагүй.

2021 онд 2,372.6 сая төгрөгийн ашигтай, 2022 онд 474.52 сая төгрөгийн ноогдол ашиг төлж, балансаар (8,249.4) сая төгрөгийн алдагдалтай ажиллаж хуримтлагдсан алдагдал (21,891.6) сая төгрөг болсон. Нийт эздийн өмч 2022 оны эхэнд 91,510.6 сая төгрөг байсан бол оны эцэст 82,743.7 сая төгрөг болж буурсан нь тайланд онд (8,249.4) сая төгрөгийн балансын алдагдалтай гарч урт хугацаат зээлийн еврогийн бодит бус ханшийн тэгшитгэл хийсэнтэй холбоотой.



НИЙТ ОРЛОГО

Борлуулалтын орлого 53,480.8 сая төгрөг төлөвлөснөөс 53,920.5 сая төгрөгийн орлоготой ажиллаж 439.7 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн нь ЦЭХ-ний орлого 357.3 сая төгрөгөөр, ДЭХ-ний орлого 82.3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой. ЦЭХ-ний борлуулалтын орлого 5,37 сая кВт.ц ЦЭХ илүү түгээснээс энерги орлого 382.3 сая төгрөгөөр, өөрийн хэрэглэсэн ЦЭХ-ний орлого 26.4 сая төгрөгөөр буурч, спотын ЦЭХ худалдан авснаас 3.8 сая төгрөг нэмж олсон, импортын хазайлтад 2.0 сая төгрөг, нэмэх зөрчилд 0.4 сая төгрөг авсныг хасаж тооцвол 49,488.8 сая төгрөг олжээ. ДЭХ 11.3 мянган Гкал илүү түгээж, 82.28 сая төгрөгөөр орлого өссөн.

Борлуулалтын орлогын 91.78 хувийг цахилгаанаас, 8.22 хувийг дулаанаас тус тус олжээ. Нийт Борлуулалтын орлогыг 2021 онтой харьцуулахад 3,112.37 сая төгрөгөөр өссөн. Энэ нь ЦЭХ-ний энерги тариф өсөж, чадлын тариф өссөн. Харин ДЭХ-ний хувьд түгээлт урд оноос 29,207.0 Гкал-р илүү түгээж, уур усны тариф өссөнөөр, дулааны орлого 32.22 сая төгрөгөөр өссөн.

Үйл ажиллагааны бус орлого гүйцэтгэлээр 15,332.0 сая төгрөгийн орлого олж төлөвлөснөөс 6,354.3 сая төгрөгөөр өссөн.

Гуанзны орлого 476.57 сая төгрөг, бусад орлого 9,852.84 сая төгрөг, валютын ханшийн бодит бус ашигт 5,002.59 сая төгрөгийн орлого тус тус олсон. Нийт орлого 62,458.5 сая төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 69,252.5 сая төгрөг гарч төлөвлөснөөс 6,794.0 сая төгрөгөөр өссөн.

НИЙТ ЗАРДАЛ

Тайлант онд өссөн дүнгээр үйлдвэрлэлийн зардлыг 62,129.7 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 61,987.2 сая төгрөг болж 142.5 сая төгрөгөөр хэмнэсэн. 2022 онд өссөн дүнгээр бусад зардалд 1,045.0 сая төгрөг төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 15,514.7 сая төгрөгийн зардал гарч төлөвлөснөөс 14,469.7 сая төгрөгөөр өссөн.

Гуанзны зардалд 842.4 сая төгрөг, бусад зардалд 308.6 сая төгрөг, валютын ханшийн бодит бус алдагдалд 14,344.3 сая төгрөг, богино хугацаат зээл 19.4 сая төгрөгийн зардал гарсан.

2022 онд өссөн дүнгээр нийт зардалд 63,174.7 сая төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 77,501.9 сая төгрөг гарч төлөвлөснөөс 14,327.2 сая төгрөгөөр хэтэрсэн.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

2022 онд Үндсэн үйлдвэрлэлийн зардлыг 62,129.7 сая төгрөгөөр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр үндсэн үйлдвэрлэлийн зардал 61,987.2 сая төгрөг болж, 142.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь хэмнэлтийн тухай хуулийн дагуу тогтмол зардлуудыг бууруулж ажилласан.

2022 оны үйл ажиллагааны нийт зардал

(сая төгрөг)

№	Зардлын төрөл	2019	2020	2021	2022	Харьцуулалт	
						2022-2021	%
1	Түлшний зардал	19,487.7	21,078.5	21,317.4	26,368.30	5,050.88	123.69
2	Усны зардал	423.5	451.0	481.3	718.82	237.49	149.34
3	Түүхий эд материалын зардал	30.0	102.4	5.9	42.58	36.64	716.02
4	Шатахууны зардал	541.9	430.9	488.8	761.13	272.30	155.70
5	Сэлбэг хэрэгслийн зардал	97.8	127.2	201.4	250.86	49.47	124.56
6	Урсгал засварын зардал	991.1	930.9	932.4	1,162.06	229.64	124.63
7	Материал, хангамж	188.8	173.2	100.5	182.56	82.10	181.72
8	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	12,257.7	12,576.9	12,231.0	13,296.27	1,065.23	108.71
9	Байгууллагаас төлөх НДШ, ЭМД	1,782.2	1,827.4	1,843.4	1,935.55	92.11	105.00
10	Ашиглалтын зардал-Цахилгаан	110.4	41.1	42.9	43.55	0.69	101.61
11	томилолтын зардал	72.2	12.0	25.1	36.02	10.92	143.48
12	Биичг хэрэг зардал	24.6	28.8	22.7	28.74	5.99	126.32
13	Холбооны зардал	12.5	12.8	13.3	12.29	(1.00)	92.45
14	Хөдөлмөр хамгааллын зардал	256.6	312.5	248.7	308.64	59.98	124.12
15	Элэгдлийн зардал	7,232.3	10,521.7	12,090.5	12,700.91	610.41	105.05
16	Үл хөдлөх хөрөнгийн татвар	274.9	459.8	531.0	534.91	3.91	100.74
17	АТӨЯХ-ийн татвар	1.3	1.4	1.5	1.63	0.09	105.56
18	Даатгалын зардал	37.2	34.7	8.7	7.87	(0.81)	90.69
19	Байгаль орчин хамгаалах зардал	31.4	18.1	13.5	101.88	88.36	753.46
20	Галын аюулаас хамгаалах зардал	44.6	33.2	47.5	33.39	(14.15)	70.23
21	Газрын төлбөр	46.4	44.0	38.3	42.57	4.25	111.09


22	Усны нөөц ашиглалтын татвар	105.0	89.1	88.2	120.42	32.17	136.46
23	Агаарын бохирдол ус бохирдуулсан төлбөр	30.9	30.9	37.9	32.93	(5.02)	86.78
24	Гүйцэтгэх удирдлагын зардал	259.5	223.3	271.9	198.93	(73.01)	73.15
25	Төлөөлөн удирдах зөвлөл,	66.9	92.4	107.1	107.57	0.44	100.41
26	Гамшгаас урьдчилан сэргийлэх зардал	-	-	124.0	29.49	(94.50)	23.78
	Турбин 5	-	-	-	-	-	-
27	Борлуулалт, маркетингийн зардал	23.1	11.4	18.3	25.56	7.22	139.38
28	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	186.0	155.2	143.6	154.90	11.30	107.87
29	Гадны үйлчилгээний хөлс	162.0	76.7	171.6	157.40	(14.24)	91.70
30	Зээлийн хүүгийн зардал	29.8	1,546.8	1,495.3	1,501.91	6.59	100.44
31	Бусад үйл ажиллагааны зардал	120.5	98.2	119.0	141.94	22.95	119.29
32	Сургалтын зардал	157.6	78.8	73.1	82.48	9.35	112.78
33	Нийгмийн зардал	877.7	1,034.9	912.8	861.09	(51.70)	94.34
	Өртөгийн дүн	45,964.1	52,656.1	54,249.1	61,987.17	7,738.05	114.26

Үйлдвэрлэлийн 33 нэр төрлийн зардлын үзүүлэлтээс 26 төрлийн зардлыг өнгөрсөн оны хэмжээнээс 0.09 сая төгрөгөөс 5,050.9 сая төгрөгөөр өсгөж, 7 нэрийн зардлыг 0.81 сая төгрөгөөс 73.01 сая төгрөгөөр тус тус бууруулж ажиллаа.

Нийт зардлын бүтцийг авч үзвэл Үүнээс 39.3 хувийг түлшний зардал буюу хувьсах зардал, 25.9-30.8 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл 14.7-22.3 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 0.98-1.2 хувийг шатахууны зардал, 1.8-2.4 хувийг урсгал засварын зардал, 0.06-2.8 хувийг зээлийн хүүгийн зардал, 1.7-1.97 хувийг нийгмийн зардал тус тус эзэлж байна.

Нийт зардал 2021 оны гүйцэтгэлээс 17,804.8 сая төгрөг буюу 29.0 хувиар өссөн. Зардлын өсөлтөд нөлөөлсөн бодит хүчин зүйлсийн талаар задаргаа тооцоонд үзүүлсэн болно.

Зардлын үзүүлэлт




Нийт зардлын 33.1%-ийг дулааны өртөг 66.9%-ийг цахилгааны өртөг эзэлж байна. Үйл ажиллагааны томоохон зардлуудыг тус бүрээр нь задаргаа тооцоог үзүүлэв.

ТҮЛШНИЙ ЗАРДАЛ

Үйл ажиллагааны зардлын 40.0-43.0 хувь эзэлж байна. 2022 онд хувьсах зардал буюу түлшинд 533.2 мянган тонн нүүрс, 93.96 тонн мазут, 35.13 тонн дизель түлш хэрэглэж 26,368.3 сая төгрөг зарцуулсан байна.

Түлшний зарцуулалт, нүүрс, мазут, дизель түлш



9 зуухны 6 зуух нь Шарын голын уурхайн 3,900 ккалори илчлэг бүхий нүүрс түлэх, 3 зуухыг бага илчлэг бүхий нүүрс түлэх технологид шилжүүлснээр Багануурын уурхайн нүүрс түлэх боломжтой болсон. Сүүлийн жилүүдэд Шарын голын уурхай, Багануурын уурхай, Улаан-Овоо уурхайнуудаас нүүрс авч байгаа бөгөөд, мазут, дизелийн түлшийг тендер зарлаж шалгарсан компаниудтай гэрээ байгуулж худалдаж авдаг.

Түлшний зардлын үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2019	2020	2021	2022	Харьцуулалт	
						2022-2021	%
Зарцуулагдах нийт нүүрс	тн	433.5	438.9	435.6	533.2	97.6	122.4
Нүүрсний газар дээрх үнэ	төг/тн	37.6	38.8	41.1	41.8	0.6	101.5
Нүүрсний бүгд үнэ	мян.төг	16,243.5	17,669.6	17,921.9	22,268.2	4,346.2	124.3
1 тн нүүрсний тээврийн зардал	төг/тнкм	5.6	5.0	6.0	6.0	0.0	100.2
Нийт нүүрсний тээврийн зардал	мян.төг	2,412.7	2,631.0	2,595.4	3,182.6	587.1	122.6
Түлшний зардлын дүн	мян.төг	18,656.1	20,300.5	20,517.4	25,450.7	4,933.4	124.0
Зарцуулагдах мазут	тн	0.1	0.1	0.1	0.1	-0.0	70.2
Нэгжийн үнэ	төг	1,535.4	1,417.1	1,404.6	588.7	-815.9	41.9
Нийт мазутын дүн	мян.төг	230.1	170.7	188.0	55.3	-132.7	29.4
Зарцуулагдах дизель түлш	тн	0.0	0.1	0.1	0.0	-0.0	66.5
Нэгжийн үнэ	төг	1,922.5	1,452.9	1,633.4	2,494.9	861.6	152.7
Нийт дизель түлшний дүн	мян.төг	83.3	82.2	86.3	87.6	1.4	101.6
Вагон ашиглалтын зардал	мян.төг	42.3	30.7	32.5	71.3	38.9	219.8
Салаа зам арчлалт хөлс	мян.төг	67.1	50.2	42.8	72.1	29.2	168.2
Салбар замд дэрийн эпюр нэмж хүчжүүлэх	мян.төг	-	-	-	-	-	-
дэр мод солих	мян.төг	-	34.5	34.5	14.9	-19.6	43.2
Төмөр замын гармын гэрлэн дохион арчлалт	мян.төг	1.8	3.0	2.8	3.5	0.7	124.3

Маркшедр		мян.төг	1.6	0.8	0.8	15.4	14.6	1,895.1
Хэвийн хорогдол	Биет хэмжээ	1.7	1.4	1.5	1.3	-0.2	87.2	106.8
	Мөнгөн дүн	62.5	58.7	61.7	55.1	-6.6	89.3	105.1
Ачаа хүргэлт пүүнд		мян.төг	5.1	4.5	4.5	5.8	1.3	128.5
Бичиг баримт		мян.төг	0.4	0.1	0.2	0.1	-0.1	46.3
Вагон сэлгээ зам		мян.төг	48.5	40.4	38.1	50.0	11.8	131.0
Таталт тавилт		мян.төг	32.7	30.3	30.0	37.9	7.9	126.4
Буулгагч нарын хөлс		мян.төг	254.4	271.6	274.9	439.3	164.4	159.8
Нүүрсний талбайн гэрэлтүүлэг	Биет хэмжээ	0.0	0.0	0.0	0.0	-	100.0	654.9
	Мөнгөн дүн	1.6	0.2	2.8	9.2	6.4	324.9	1,334.2
Бусад тээвэр бэлтгэл ажиллагааны зардлын дүн		мян.төг	518.1	525.1	525.8	774.6	248.8	147.3
Нийт түлшний зардлын дүн		мян.төг	19,487.7	21,078.5	21,317.4	26,368.3	5,050.9	123.7

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ

Компани 2022 оны гүйцэтгэлээр 361.42 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ажилласан. Жил бүр их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээгээр хэрэгжүүлсэн ажлын дүнгээр 5.4–8.2 тэрбум төгрөгөөр хөрөнгө нэмэгддэг, 0.3–0.5 тэрбум төгрөгийн хөрөнгө эдэлгээний хугацаа дуусаж хасагддаг.

2009 онд ихэнх үндсэн тоноглолууд элэгдлээрээ өртгөө нөхөөд үнэгүйдсэн байдлыг ТӨХ болон холбогдох байгууллагуудад танилцуулан хуулийн дагуу хөрөнгийн үнэлгээний компаниар үнэлгээ хийлгэж хөрөнгийн эдэлгээний хугацааг тооцож тогтоосон 2009 оны 01 сарын 01-нд 27.0 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн нь дахин үнэлгээгээр 75.3 тэр бум төгрөгөөр бүртгэгдэж тайланд туссан.

Хөрөнгийн үнэлгээний дараа өртөгт тусах элэгдлийн хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос хэрэглэгчийн үнэд нөлөөлөхгүй хэмжээнд үе шаттайгаар бүтээгдэхүүний тарифт тусгахаар шийдвэр гарсан.

Элэгдлийн зардал 2023 онд 12.7 тэрбум төгрөг гарч байгаа болно. Өртөгт 20.5 хувийг эзэлж байна. Элэгдлийн зардлыг Эрчим Хүчний Зохицуулах Хорооны 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 53 дугаар тогтоолыг үндэслэн тооцов.

2022 оны үндсэн хөрөнгийн элэгдлийн үзүүлэлт

№	Үндсэн хөрөнгийн төрөл	Өмнөх тарифт туссан			2022 он		
		Үндсэн хөрөнгө	Элэгдэл		Үндсэн хөрөнгө	Элэгдэл	
1	Барилга, байгууламж	46,600.0	1,143.2	2.5%	74,151.9	1,860.0	2.5%
2	Машин тоног төхөөрөмж	152,376.2	5,529.2	3.63%	253,020.6	9,835.4	3.7%
3	Компьютер мэдээлэл бол-х	2,343.1	95.4	4.1%	1,679.7	69.0	4.1%
4	Тээврийн хэрэгслэл	1,862.1	229.3	12.3%	2,514.5	410.0	16.3%
5	Тавилга эд хогшил	571.4	39.3	6.9%	937.7	65.0	6.9%
6	Биет бус хөрөнгө	493.2	74.0	15.01%	3,070.7	461.0	15.0%
7	Дуусаагүй их засвар	3,426.5	0.0	0.0%	3,432.8	0.0	0.0%
8	Дуусаагүй барилга	8.9	0.0	0.0%	8.9	0.0	0.0%
9	Газрын эрх				22,603.1		
	ДҮН	207,681.4	7,110.4	3.4%	361,419.9	12,700.4	3.3%

ТЕХНОЛОГИЙН БОЛОН АШИГЛАЛТЫН УСНЫ ЗАРДАЛ

Үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд 2.2 сая тонн цэвэр ус зарцуулж, 0.08 сая тонн бохир ус зайлуулдаг. Үйлдвэрлэлийн хэрэгцээний усны 99.6-99.8 хувийг Хараа голын сав газрын дагуу байрлах компанийн 8 гүний худгаас олборлодог. Үлдсэн хувийг нь буюу 0.2 хувийг Дархан-Ус суваг ХК-аас худалдаж авдаг. 2015 онд Дархан хотын хэмжээнд хаалттай системд шилжиж байгаатай холбогдон 0.9 сая тонн ус буурч байсан.

Өмнө нь өөрийн худаг гаргаагүй байхад усны зардал нь өртгийн 12.5-13 хувийг эзэлдэг байсан бол одоо 1.2-1.5 хувийг эзэлж байна.

Усны зардал

№	Үзүүлэлт	Хэмж нэгж	2019	2020	2021	2022	харьцуулалт	
							2022-2021	%
1	Цэвэр ус	мян.тн	1,693.2	1,753.3	1,839.3	1,780.3	(59.0)	96.8
		төг	158.9	167.8	175.6	294.4	118.8	167.6
		бүгд	269,062.0	294,157.7	323,028.6	524,144.5	201,115.9	162.3
2	Бохир ус зайлуулалт	мян.тн	76.1	73.5	75.5	73.5	(2.0)	97.4
						43.0	43.0	
		төг	2,030.0	2,030.0	2,095.4	2,647.0	551.6	126.3
	бүгд	154,468.7	149,295.3	158,295.3	194,673.4	36,378.1	123.0	
3	Усны зардал	мян.төг	423,530.6	443,453.0	481,323.9	718,817.9	237,494.0	149.3
	Үүнээс:							
а	Гүний худаг	мян.тн	1,688.5	1,748.7	1,835.0	1,775.7	(59.3)	96.8
		төг	154.2	163.2	171.1	288.8	117.7	168.8
		бүгд	260,299.0	285,413.6	313,884.6	512,827.8	198,943.2	163.4
б	Дархан Ус суваг ХК	мян.тн	4.6	4.6	4.3	4.6	0.3	106.9
		суурь хур				1,720.6	1,720.6	
		төг	1,893.5	1,893.5	1,893.5	2,450.6	557.1	129.4
		бүгд	8,763.0	8,744.0	9,144.0	11,316.7	2,172.6	123.8

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БУС ЦАХИЛГААНЫ ЗАРЦУУЛАЛТ

Үйлдвэрлэлийн бус буюу эрчим хүч үйлдвэрлэхэд шууд зарцуулагддаггүй, үйлдвэрийн цех нэгжүүдийн хэрэглээнд жилд 0.4-1.0 сая кВтц цахилгаан эрчим хүч зарцуулдаг.

Энэ нь зардлын 0,1-0,3 хувийг эзэлдэг. Нэгж үнийг компанийн өөрийн борлуулалт гэж үзэж хэрэглэгчдэд түгээх үнээр тооцдог.

Цахилгааны зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	2019	2020	2021	2022
1	Цахилгааны хэрэглээ	мян.квт	268.9	811.9	411.1	588.39
2	Нэгж үнэ	төг/квтц	152.80	152.80	152.80	164.33
3	Цахилгаан зардлын дүн	мян төг	41085.9	124059.8	62816.7	96690.29

УРСГАЛ ЗАСВАР, ХАНГАМЖИЙН МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ

Компанийн хэмжээний 615 тоноглолд хийгдэж байгаа урсгал засварын зардалд жилд 765.7- 1,432.9 сая төгрөг зарцуулагддаг, өртөгт 0.4–2.2 хувийг эзэлдэг.

Тоног төхөөрөмжийн сэлбэг импортоор орж ирдэг, валютын ханшийн өсөлтөөр үнэ жил бүр өсдөг нь зардлын өсөлтөд нөлөөлдөг.

Урсгал засвар, хангамжийн материал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	2019	2020	2021	2022	Харьцуулалт	
							2022-2021	%
1	Урсгал засварын зардал	мян төг	991.1	930.9	932.4	1162.06	229.6	124.6
2	Материал, хангамжийн материал	мян төг	188.8	173.2	100.5	182.56	82.1	181.7

Урсгал засварын зардлын өсөлтөд гол нөлөөл нь тоног төхөөрөмжийн сэлбэгийн үнийн дундаж өсөлт, олон жил болсон барилга байнгын чичиргээ доргионоос хамааран ан цав үүсэх зэрэг барилгын засварын ажлын эзлэхүүн нэмэгдсэн нь голлох нөлөөлөл болж байна.

УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Удирдлагын зардалд жилд 198.93 сая төгрөг зарцуулагддаг нь өртгийн 0.2%-ийг эзэлдэг.

Удирдлагын зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	2019	2020	2021	2022	Харьцуулалт	
							2022-2021	%
1	Гүйцэтгэх удирдлагын зардал	сая төг	259.5	223.3	271.9	198.93	(73.0)	73.15
а	Цалин	сая төг	197.4	181.5	222.1	153.37	(68.8)	69.04
б	шимтгэл	сая төг	28.6	26.3	33.4	22.24	(11.2)	66.52
в	Томилолт	сая төг	9.4	0.4	1.3	1.58	0.3	119.18
г	Шатахуун	сая төг	18.1	9.4	10.1	14.18	4.1	140.22
д	Холбоо	сая төг	2.3	1.6	2.0	0.93	(1.1)	46.07
е	Бичиг хэрэг	сая төг	0.6	-	0.2	0.12	(0.1)	56.91
ё	хангамжийн материал	сая төг	0.7	1.4	1.0	5.30	4.3	545.97
ж	Бусад	сая төг	2.4	2.7	1.7	1.22	(0.5)	70.07

ТАТВАР, ДААТГАЛ, ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ЗАРДАЛ

Үл хөдлөх хөрөнгийн татвар, Авто тээврийн өөрөө явах хэрэгслийн татвар, эзэмшил газрын татвар, усны нөөц ашиглалтын татварт жилд 357.6-625.2 сая төгрөг зарцуулдаг. Дээрх зардал нь өртгийн 0.9-1.2 хувийг эзэлдэг.

Татвар, хураамжийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	2019	2020	2021	2022	Харьцуулалт	
							2022-2021	%
1	Үл хөдлөх хөрөнгийн татвар	сая төг	274.9	459.8	531.00	534.91	3.9	100.7
2	АТӨЯХ-ийн татвар	сая төг	1.3	1.4	1.54	1.63	0.1	105.6
3	Даатгалын зардал	сая төг	37.2	34.7	8.68	7.87	(0.8)	90.7
4	байгаль орчин хамгаалах зардал	сая төг	31.4	18.1	13.52	101.88	88.4	753.5
6	Газрын төлбөр	сая төг	46.4	44.0	47.54	42.57	4.3	111.1

7	Усны нөөц ашиглалтын татвар	сая төг	105.0	89.1	88.25	120.42	32.2	136.5
8	Агаарын бохирдол	сая төг	30.9	30.9	37.95	32.93	(5.0)	86.8
	ус бохирдуулсан төлбөр	сая төг				2.01	2.0	
	Нийт дүн	сая төг	571.8	711.3	728.48	844.23	125.0	117.4

2022 онд 2021 оны гүйцэтгэлийн дүнгээс 125.0 сая төгрөгөөр өссөн гол нөлөөлөл нь байгаль хамгаалах зардал, усны нөөцийн татвар, ус бохирдуулсны татвар өссөн.

НИЙГМИЙН ЗАРДАЛ

Тайлант онд компанийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зорилгоор ажлын байрны болон хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулах, ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх зорилгоор 9 бүлэг, 101 заалт бүхий хамтын гэрээг компанийн ҮЭХ-той байгуулан бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Компани ажилтнуудаас 2022 онд 36 өргөдөл хүлээн авч нийт 12 ажилтанд 108 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлсэн байна.

Ажиллагсдын нийгмийн зардал

(Сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл			2022	Өөрчлөлт
		2019	2020	2021		2022-2021
1	Шагнал	125.95	77.37	124.54	202.20	77.66
2	Буцалтгүй тусламж, тэтгэмж	42.94	33.72	44.16	68.41	24.25
3	Тэтгэвэрт суух тэтгэмж	160.91	453.63	488.19	397.01	-91.18
4	Сувиллын хөнгөлөлт	2.17	3.61	0.56		-0.56
5	Хоолны хөнгөлөлт	271.58	282.12	66.88	0.99	-65.89
6	Биеийн тамир, соёлын арга хэмжээ	41.13	2.11	8.72	67.13	58.41
7	Баяр ёслолын арга хэмжээ	84.98	36.27	34.92	64.93	30.01
8	Нөхөн олговор	42.91	-	-	-	
9	Эмнэлэг, эмчилгээний зардал	29.07	43.85	45.83	60.42	14.59
10	Бусад зардал /орон сууцны хөн-лт/	76.00	102.19	99.00		-99

Компани 2022 онд ажилтнуудын нийгмийн зардалд 861.09 сая төгрөг зарцуулсан бөгөөд энэ компанийн нийт зардлын 2 хувийг эзэлж байна.

Үүнд:

- ❖ 14 хүн тэтгэвэрт гарсан.
- ❖ Буцалтгүй тусламжийг жилд дунджаар 20-40 хүн олгодог.
- ❖ Ажил, мэргэжлийн уралдаан.
- ❖ Алба, хэлтэс, цехүүд, удирдлагын аваргуудыг оны эцэст хамтын гэрээний дагуу шалгаруулж байр эзлүүлсэн.
- ❖ Төрийн болон яам, аймаг, сумын шагнал урамшуулал.
- ❖ Компанийн ажилтнуудын хүүхдүүдэд өгөх бэлэг.
- ❖ Улсын баяр, наадмаар наадмын талбайд 5 хоног гэр барихад шаардагдах тавгийн идээ айраг, хоол, цай ууц гэх мэт зүйлсийн зардал.
- ❖ Эрчим хүчний салбарын 100 жилийн ойн арга хэмжээ, аймаг болон компанийн зүгээс зохион байгуулсан тэмцээн, уралдааны бооцоо, шагнал урамшуулал, тамирчдын хувцас авах зардлууд багтсан.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ

Тус компанийн 2022 оны нийт орлого, үйл ажиллагааны нийт зардлын дүнгээр **(8,249.41)** сая төгрөгийн балансын алдагдалтай ажилласан.

ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ

Үндсэн бус үйл ажиллагаанаас 15,332.0 сая төгрөгийн орлого олж 15,514.7 сая төгрөгийг зарцуулж 182.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Үндсэн бус үйл ажиллагааны 2019-2022 оны үзүүлэлт



Тайлант онд үндсэн бус үйл ажиллагааны зардалд компанийн 246 өндөр настан, мэргэжлээс шалтгаалах өвчний учир хөдөлмөрийн чадвар алдсан 3 хүнтэй холбоотой зардлууд гарсан.